



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/118

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн Сайд (Б.Жавхлан), Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга (Н.Учрал) нарт тус тус зөвлөсүгэй.

4.Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцож ажиллахыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор (Т.Байгалмаа), Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч (С.Батбямба) нарт тус тус даалгасугай.

5.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын баримтыг хадгаламжийн нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор (Т.Байгалмаа)-т үүрэг болгосугай.


Д.ЗАГДЖАВ



ᠠᠷᠬᠠᠩᠭ᠋ᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠭᠠᠰᠠᠷ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ НЬ ОНХС-ИЙН ТӨСВИЙГ БАТЛАХДАА
ИРГЭДИЙН САНАЛГҮЙ, ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ӨӨРЧЛӨН
БАТАЛЖ БАЙГААД ЧИГЛЭСЭН ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ БАЙНА

АУДИТЫН КОД:

АРА-2024/26/-ШТА-ГА



ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2024 ОН

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Алтантуяа

Утас: 70333019 Цахим хаяг: altantuyan@audit.gov.mn

Ахлах аудитор П.Цэцэгдулам

Утас: 70333019 Цахим хаяг: tsetsegdulamp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



Тайлан бэлтгэсэн: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Аудитын менежер Д.Нэргүйбаатар Ахлах аудитор Н.Алтантуяа П.Цэцэгдулам Аудитор Л.Соёлмөнх В.Цогжаргал 2024 оны 11 дүгээр сар Уг тайланг www.audit.mn сайтаас үзнэ үү. Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033- 3141 дугаарын факсаар харилцана уу Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот	Агуулга Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Үндсэн мэдээлэл Аудитын тайлан БҮЛЭГ 1. АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРЭГ НЬ ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ ЭХ ҮҮСВЭР ТУС БҮРЭЭР БҮРЭН ТӨЛӨВЛӨХ ТАЛААР САНААЧИЛГАТАЙ АЖИЛЛААГҮЙ, ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТӨД ИРГЭД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА 1.1 ОНХС-ийн эх үүсвэр нь татварын орлогын гүйцэтгэлээс шалтгаалж 7,247.8 сая төгрөгөөр дутуу бүрджээ 1.2 Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь иргэдийн саналаар дэмжигдээгүй, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталдаг зөрчил давтагдсаар байна БҮЛЭГ 2. ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ УРСГАЛ ШИНЖТЭЙ ЗАРДАЛД ЗАРЦУУЛЖ БАЙГАА НЬ ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ БАЙНА 2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөвт өртгийг хэт жижиглэснээс тендер оролцогчгүй болох, оройтох, ажил он дамнах төсөл арга хэмжээний гүйцэтгэл, чанарт сөргөөр нөлөөлж байна 2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 97.8 хувь нь төлөвлөсөн зорилтот түвшний үр дүндээ хүрсэн байна 2.3 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон зарим хөрөнгө ашиглалтгүй байна БҮЛЭГ 3 ОНХС-ИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ БОЛОН УДИРДЛАГА МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД ИЛ ТОД, ҮНЭН ЗӨВ МЭДЭЭЛЭХ БАЙДАЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА 3.1 ОНХС-ийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна 3.2 ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг иж бүрэн тайлагнахгүй байна Дүгнэлт..... Зөвлөмж Холбогдох байгууллагын санал Тайлан баталгаажуулсан тушаал..... Хавсралт:Судалгаанууд	2 3-5 6-8 9-50 10-22 22-38 39-46 47 48 49 50 51-65
--	--	---

**Товчилсон үгийн тайлбар**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АМАТЗ	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл
АМХТЗ	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл
ГТНАТ	Газрын тосны нөөц ашигласны төлбөр
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЖГҮ	Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МТТАТ	Малын тоо толгойн албан татвар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
УУХҮС	Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд
УМС	Удирдлагын мэдээллийн систем
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХШҮДАХ	Хяналт шинжилгээ-үнэлгээ дотоод аудитын хэлтэс

**Хүснэгтийн жагсаалт**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ОНХНС-ийн төлөвлөлт	6
Хүснэгт 2	ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл	7
Хүснэгт 3	ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл	9
Хүснэгт 4	ОНХНС-аас аймаг, нийслэлд олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл	10
Хүснэгт 5	ОНХС-ийн эх үүсвэр	11
Хүснэгт 6	Тогтвортой амьжиргаа 3 төслийн ЖГҮ-ний дундаж, олгосон санхүүжилт	13
Хүснэгт 7	ОНХС-ийн 2023 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ	24
Хүснэгт 8	ТАХ-ний зорилтот түвшинд хүрсэн байдал	28
Хүснэгт 9	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний ангилал	30
Хүснэгт 10	Хөрөнгийн ашиглалтын байдал	34
Хүснэгт 11	Хадгалалт, хамгаалалт алдагдсан төсөл, арга хэмжээ	37
Хүснэгт 12	ОНХС-ийн хяналт аймаг, нийслэлээр	39
Хүснэгт 13	Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт	42
Хүснэгт 14	Удирдлагын мэдээллийн системийн мэдээлэл	44
Хүснэгт 15	УМС болон судалгааны мэдээллийн харьцуулалт	44

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ОНХНС-аас олгосон санхүүжилт	11
Дүрслэл 2	2022-2023 оны бэлчээрийн даацын мэдээ	12
Дүрслэл 3	Иргэдийн санал өгсөн байдал	15
Дүрслэл 4-7	ОНХС-ийн санал асуулга	16
Дүрслэл 8	Аймаг, нийслэлийн чиг үүрэг	21
Дүрслэл 9	Сум, дүүргийн чиг үүрэг	21
Дүрслэл 10	Ашиглагч байгууллагын чанарын үнэлгээ ТАХ-ний тоогоор	35
Дүрслэл 11	ОНХС-ийн хяналт	37
Дүрслэл 12	Захиалагчийн хяналт	39



Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/100 дугаар тушаалаар баталсан “Аудитын сэдэв батлах тухай”, 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Аудитын жилийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн гүйцэтгэв.

Аудитын зорилт

Аудитыг “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Сангийн яам болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, ЗДТГ, СТСХ, баг, хороодын Засаг дарга, аймаг, сумын ОНХС-ийн 2023 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817- 1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- ✓ Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт;
- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;



- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”;
- ✓ Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- ✓ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- ✓ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”;
- ✓ Сангийн сайдын 2016 оны 17 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ), ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос ОНХС-д олгох шилжүүлэг тооцох аргачлал”
- ✓ Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд



ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Орон нутгийн хөгжлийн сангийн (цаашид ОНХС гэх) зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг.

ОНХС нь нутгийн иргэдийн оролцоотойгоор тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэрэгсэл бөгөөд тухайн орон нутгийн иргэд нь өөрсдөө тус сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөлд оролцох боломжтой юм.

Төсвийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйлд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан (цаашид ОНХНС гэх) болон ОНХС-ийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, хуваарилалтыг зохицуулсан бөгөөд ОНХС-ийн үйл ажиллагаанд Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан журмыг мөрдөж байна. 2023 оныг дуустал ОНХНС болон ОНХС-аас орлогын шилжүүлгийг тооцож олгохдоо Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан аргачлалыг мөрдсөн бөгөөд ЗГ-ийн 2023 оны 457 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, 2024 оноос мөрдөж эхэлжээ.

Монгол орны хөдөө орон нутагт нэн тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд засаглал болон иргэд, олон нийтийн оролцоог сайжруулах зорилготой “Тогтвортой амьжиргаа 3” төслийг Олон Улсын Хөгжлийн Ассоциаци болон Монгол Улсын Засгийн газар хооронд 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан №5487-MN дугаартай санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу 2015-2023 онуудад амжилттай хэрэгжүүлж дууссан байна.

Сангийн Яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс “Тогтвортой амьжиргаа-3” төслийн 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 93.4 оноо буюу “Маш сайн” гэсэн үнэлгээг өгсөн байна.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 298,478.6 сая төгрөгөөр баталсан бөгөөд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого өссөнтэй уялдуулан хуульд 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 71,460.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 369,939.3 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Хүснэгт 1. ОНХНС-ийн төлөвлөгөө

(сая төгрөгөөр)

№	Аймаг, нийслэл	ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг (Төсвийн тухай хууль 2022.11.11)	ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг (Төсвийн тухай хууль 2023.06.16)	Үүнээс: "Тогтвортой амьжиргаа 3" төслийн урамшуулал	Тодотголоор нэмж батлагдсан дүн
А		1	2	3	4=2-1
1	Аймаг	265,978.9	328,614.2	15,930.5	62,635.3
2	Нийслэл	32,499.7	41,325.1	-	8,825.4
Дүн		298,478.6	369,939.3	15,930.5	71,460.7

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль

"Тогтвортой амьжиргаа 3" төслийн урамшууллаар 2023 онд 21 аймгийн 218 суманд ОНХС-ийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн нийт 15,930.5 сая төгрөгийг төлөвлөж, санхүүжүүлжээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдсан ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг дээр нэмж аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ нь Төсвийн тухай



хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-д заасны дагуу 174,450.7 сая төгрөгийн эх үүсвэрийг нэмж төлөвлөн баталжээ.

Улсын хэмжээнд 2023 онд ОНХС 87,256.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба сангийн эх үүсвэрт нийт 544,390.0 сая төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 426,489.7 сая төгрөгийг бүрдүүлэн тайлангийн жилд ОНХС-аас 408,507.6 сая төгрөгийг зарцуулж, жилийн эцэст 105,238.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөг)

№	Аймаг, нийслэл нэр	ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдэл	Нийт эх үүсвэр		Төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх зарлагын нийт дүн	ОНХС-ийн харилцах дансны эцсийн үлдэгдэл
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
А		1	2	3	4	5=1+3-4
1	Архангай	2,976.4	16,105.5	12,341.7	12,226.4	3,091.7
2	Баянхонгор	2,966.8	25,252.2	20,905.4	20,940.9	2,931.3
3	Баян-Өлгий	1,281.0	11,595.6	10,263.8	8,687.5	2,857.3
4	Булган	2,633.4	14,685.7	11,928.2	10,943.5	3,618.1
5	Говь-Алтай	2,934.4	19,669.8	16,056.8	16,388.3	2,602.9
6	Говь-сүмбэр	705.6	6,759.2	5,905.3	4,243.1	2,367.8
7	Дархан-Уул	3,825.9	17,486.2	13,592.1	13,217.9	4,200.1
8	Дорноговь	9,817.5	38,310.5	27,575.4	34,567.8	2,825.2
9	Дорнод	2,581.6	31,231.3	27,867.5	25,545.5	4,903.6
10	Дундговь	4,063.0	18,535.7	13,204.3	12,788.4	4,478.9
11	Завхан	1,945.1	19,708.9	15,985.6	16,475.7	1,455.0
12	Орхон	932.6	20,680.5	19,427.9	15,408.3	4,952.2
13	Өвөрхангай	3,721.3	18,790.5	14,257.9	14,419.1	3,560.1
14	Өмнөговь	6,666.5	45,396.4	38,191.2	34,014.4	10,843.3
15	Сүхбаатар	1,640.6	33,079.5	19,303.0	17,245.8	3,697.8
16	Сэлэнгэ	4,057.2	28,165.2	22,642.0	22,112.1	4,587.1
17	Төв	3,844.2	34,792.4	26,278.2	25,806.9	4,315.5
18	Увс	1,171.6	14,093.1	12,526.9	10,370.6	3,327.8
19	Ховд	3,468.6	32,572.8	27,856.0	26,029.6	5,295.0
20	Хөвсгөл	3,425.4	20,744.2	16,036.4	15,108.3	4,353.5
21	Хэнтий	2,453.2	15,783.0	13,423.5	13,770.8	2,105.9
Аймгийн дүн		67,111.9	483,438.2	385,569.1	370,310.9	82,370.1
22	Нийслэл	20,144.2	60,951.8	40,920.8	38,196.9	22,868.1
Нийт дүн		87,256.1	544,390.0	426,489.7	408,507.6	105,238.2

Эх сурвалж: Аудитын нэгтгэсэн судалгаа -АНТАГ

ҮАГ-аас нэгдсэн удирдамжаар 2022 онд “Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Сангийн сайдад 3, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дарга нарт 1, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт 4 нийт 8 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Аудитын явцад ОНХС-ийн үйл ажиллагаанд оролцох иргэдийн идэвх оролцоо, мэдээлэл ямар байгааг судлах, нэгтгэн дүгнэж аудитын тайланд тусган холбогдох албан тушаалтнуудад



танилцуулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал зөвлөмжийг боловсруулах зорилгоор судалгаа, санал асуулгыг **гүүгл форум** (google forum) ашиглан 21 асуултын хүрээнд 21 аймаг, нийслэлийн нийт 7,694 иргэнээс цахимаар, 361 иргэнээс цаасаар авч нэгтгэн дүн шинжилгээ хийж, тайланд тусгав.



БҮЛЭГ 1: АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРЭГ НЬ ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ ЭХ ҮҮСВЭР ТУС БҮРЭЭР БҮРЭН ТӨЛӨВЛӨХ ТАЛААР САНААЧИЛГАТАЙ АЖИЛЛААГҮЙ, ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТӨД ИРГЭД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА

1.1 ОНХНС-ийн эх үүсвэр нь татварын орлогын гүйцэтгэлээс шалтгаалж 7,247.8 сая төгрөгөөр дутуу бүрджээ.

1.1.1 ОНХНС-ийн эх үүсвэрийн 85.9 хувийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ), 5.1 хувийг газрын тосны нөөц ашигласны төлбөр (ГТНАТ), 4.7 хувийг ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр, 4.3 хувийг “Тогтвортой амьжиргаа 3” төслийн урамшууллаас бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2¹, 59.1.3², 59.1.5³-т заасны дагуу ОНХНС-ийн эх үүсвэрийг нийт 369,939.3 сая төгрөгөөр төлөвлөн, 362,691.5 сая төгрөгийг бүрдүүлж, гүйцэтгэл 98.0 хувьтай байна.

Хүснэгт 3. ОНХНС- эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөг)

№	Эх үүсвэр	2022 он			2023 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	АМНАТ- 10%	200,235.2	200,235.2	-	317,814.3	317,814.3	-
2	ГТНАТ- 30%	6,208.3	6,208.3	-	18,850.7	13,388.6	5,462.1
3	Урамшуулал /Тогтвортой амьжиргаа 3 төсөл /	6,999.9	6,999.9	-	15,930.5	15,930.5	-
4	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр -100%	7,021.6	6,321.3	700.3	4,966.7	4,476.0	490.7
5	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр - 50%	12,179.3	11,786.5	392.8	12,377.1	11,082.1	1,295.0
Дүн		232,644.3	231,551.2	1,093.1	369,939.3	362,691.5	7,247.8

Эх сурвалж: Сангийн Яамнаас ирүүлсэн судалгаа

Тайлангийн жилд ОНХНС-д төвлөрүүлэх ГТНАТ-ийн орлогыг 5,462.1 сая төгрөг, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг 1,785.7 сая төгрөг, нийт 7,247.8 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна. Энэ талаар АМГТГ-аас тодруулахад дараах тайлбарыг өгсөн. Үүнд:

- ✓ Газрын тосны орлого нь 2023 онд тасарч, 71.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан.
- ✓ Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу хугацаа дуусгавар болсон, цуцлагдсан, тусгай зөвшөөрлийн талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаасан зэргээс шалтгаалж, 2023 оны төсвийн төсөлд төлөвлөгдсөн ашигт малтмалын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого нь бүрэн төвлөрөхгүй нөхцөл үүсэж, тухайн аймаг, сумдад санхүүжилтийг орлогын гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

1.1.2 Сангийн Яамнаас Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3⁴, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн

¹ 59.1.2. Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь;

² 59.1.3 Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;

³ 59.1.5 Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.

⁴ 59.3. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно: 59.3.1. орон нутгийн хөгжлийн индекс; 59.3.2. хүн амын тоо; 59.3.3. нутаг дэвсгэрийн хэмжээ; 59.3.5. өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ.



хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын 3.1⁵, 3.2⁶-т заасны дагуу ОНХНС-аас олгох шилжүүлгийг батлагдсан маягтын дагуу аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрээр тооцсон байна. Аргачлалын дагуу хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарч итгэлцүүрээр сумдад 168,332.0 сая төгрөг, "Тогтвортой амьжиргаа 3" төслийн урамшуулал 15,930.5 сая төгрөг, АМХТЗ-ийн төлбөрөөс 2,483.0 сая төгрөг, АМАТЗ-ийн төлбөрөөс 6,169.7 сая төгрөг, нийт 192,915.2 сая төгрөгийг сумдад, 177,024.1 сая төгрөгийг аймаг, нийслэлийн ОНХС-д хуваарилжээ.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.6 дахь заалт нь 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар хүчингүй болж, 2018 онд уг хуулийн 60.2.7-д "Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос ... 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, ... ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь" гэсэн нэмэлт өөрчлөлт орсон байхад Сангийн сайдын 2016 оны 17 дугаар тушаалаар баталсан "Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ), ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос ОНХС-д олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ыг энэ өөрчлөлттэй нийцүүлж шинэчлээгүй байна.

Аудитаас дээрх аргачлалыг шинэчлэн батлах зөвлөмжийг Сангийн яаманд хүргүүлжээ.

ОНХНС-ийн 2023 оны эх үүсвэрийг бүрдүүлж буй төлбөр хураамжийн орлогын гүйцэтгэлээс шалтгаалж, аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 88.2-1,298.8 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Хүснэгт 4. ОНХНС-ийн 2023 оны орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, нийслэлээр

(сая төгрөг)

№	Аймаг, нийслэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	А	1	2	3=1-2	4
1	Архангай	10,740.4	10,571.3	169.1	98.4
2	Баян-Өлгий	10,073.8	9,911.9	161.9	98.4
3	Баянхонгор	15,405.3	15,192.5	212.8	98.6
4	Булган	9,369.0	9,051.7	317.3	96.6
5	Говь-Алтай	15,122.9	14,863.8	259.1	98.3
6	Дорноговь	26,870.3	25,571.5	1,298.8	95.2
7	Дорнод	21,499.6	20,380.6	1,119.0	94.8
8	Дундговь	11,875.4	11,563.1	312.3	97.4
9	Завхан	15,043.1	14,836.0	207.1	98.6
10	Өвөрхангай	12,166.4	11,925.2	241.2	98.0
11	Өмнөговь	28,685.0	28,262.1	422.9	98.5
12	Сүхбаатар	17,153.7	16,990.8	162.9	99.1
13	Сэлэнгэ	20,328.8	20,170.5	158.3	99.2
14	Төв	20,671.3	20,398.1	273.2	98.7
15	Увс	11,324.1	11,080.4	243.7	97.8
16	Ховд	19,255.4	19,050.9	204.5	98.9
17	Хөвсгөл	14,403.3	14,200.9	202.4	98.6
18	Хэнтий	12,451.3	12,166.1	285.2	97.7
19	Дархан-Уул	13,473.2	13,362.8	110.4	99.2
20	Улаанбаатар	41,325.1	40,715.6	609.5	98.5
21	Орхон	16,970.4	16,782.3	188.1	98.9
22	Говьсүмбэр	5,731.5	5,643.3	88.2	98.5
	Дүн	369,939.3	362,691.5	7,247.8	98.0

Эх сурвалж: Сангийн Яамнаас ирүүлсэн судалгаа


⁵ Тухайн төсвийн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг тооцох дор дурдсан итгэлцүүрийг холбогдох байгууллагаас хамгийн сүүлд гаргасан албан ёсны мэдээлэлд үндэслэнэ.

⁶ Энэ аргачлалын 2.1-д заасан эх үүсвэрээс бүрдэх орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгийг дор дурдсан байдлаар хувийн жинд харгалзуулан орлогын шилжүүлгийн хуваарилалтыг тооцно.



ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн сар улирлын хуваарийн хэрэгжилтийг авч үзэхэд 1, 2 дугаар улиралд хуваариас дутуу, харин 3,4 дүгээр улиралд нөхөж олгожээ.

Дүрслэл 1. ОНХНС-аас олгосон санхүүжилт улирлаар (сая төгрөгөөр)



Орлогын шилжүүлгийн 40.4 хувийг 1, 2 дугаар улиралд, 60.6 хувийг 3,4 дүгээр улиралд олгохоор хуваарийг хийсэн байна. Оны сүүл буюу 4 дүгээр улиралд санхүүжилтийг өндөр дүнгээр хуваарилан олгож байгаа нь тухайн онд төлөвлөсөн төсөл арга хэмжээ цаг хугацаандаа хэрэгжихгүй, он дамжих эрсдэлийг бий болгож байх тул төсөл арга хэмжээ хэрэгжих боломжит улиралд санхүүжилтийг хуваарилдаг байх нь зүйтэй байна.

1.1.3 Аймаг, нийслэлийн ОНХС-аас сум, дүүргийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг эх үүсвэрийн бүрдүүлэлтээс шалтгаалан дутуу хуваарилсан байна.

Дархан-Уул аймгийн ОНХС-аас сумдад санхүүжилтийг олгохдоо 1,348.7 сая төгрөгийг дутуу олгож, Баян-Өлгий, Хөвсгөл аймгууд орлогын шилжүүлгийг аймгийн Засаг даргын баталсан хуваарийн дагуу шилжүүлээгүй байна.

1.1.4 Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь ОНХС-ийн 2023 оны эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т заасны дагуу нийт 544,390.0 сая төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 5. ОНХС-ийн эх үүсвэр

(сая төгрөг)

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Эзлэх хувь
1	ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг	354,008.8	65.0
2	Төсвийн тухай хуулийн 59.1.3 дахь заалтын хүрээнд "Тогтвортой амьжиргаа 3" төслийн урамшуулал	15,930.5	2.9
3	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлийг ИТХ-аас баталсан (СЯ-ны э-тайлангаас урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх дүнгээр авсан)	86,780.5	15.9
4	Төсвийн тухай хуулийн 60.2.4 дахь заалтын хүрээнд Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр	16,114.8	3.0
5	Төсвийн тухай хуулийн 60.2.5 дахь заалт, ЗГ-ын 2017 оны 230-р тогтоолын 2.2.4 дахь заалтын хүрээнд тухайн ОНХ-ийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламж, ОУБ-ийн төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг	35,345.8	6.5
6	Малын тоо толгойн татварын орлого	30,402.2	5.6
7	Бусад орлого	5,807.4	1.1
ДҮН		544,390.0	100.0

Эх сурвалж: АНТАГ-ын аудитын явцад хийгдсэн судалгаа
(Дэлгэрэнгүйг судалгаа 1-ээс харна уу)

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.4⁷-т заасан эх үүсвэрийг 16,114.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 8,208.1 сая төгрөг буюу 50.9 хувьтай байна. Сүхбаатар аймаг хамгийн өндөр дүнгээр буюу 9,233.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,235.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

⁷ Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;




Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5⁸-т заасан эх үүсвэрийг 35,345.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 27,407.2 сая төгрөг буюу 77.5 хувьтай байна. Хамгийн өндөр дүнгээр төлөвлөсөн аймгуудын гүйцэтгэлийг авч үзвэл Ховд аймаг 8,143.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 7,745.3 сая төгрөг, Төв аймаг 7,062.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 4,476.3 сая төгрөг, Дорнод аймаг 5,182.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 4,919.9 сая төгрөг, Өмнөговь 5,000.0 сая төгрөгөөр төлөвлөж, 4,000.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 -т заасны дагуу ОНХС-ийн эх үүсвэрт малын тоо толгойн албан татварын (цаашид МТТАТ гэх) орлогоор аймаг, нийслэл нь 30,402.2 сая төгрөгийг төвлөрүүлэхээр тооцсон боловч 22,869.8 сая төгрөгийг төвлөрүүлж, орлого улсын хэмжээнд 7,532.4 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь сүүлийн 2 жилд Монгол орны ихэнх нутгаар өвөлжилт, хаваржилт хүндэрч мал ихээр хорогдсон, сумдын ИТХ-аас малын тоо толгойд ногдох албан татварыг аймаг, сумд харилцан адилгүй тогтоосон, зарим сумд орон тооны татварын байцаагчгүй зэрэг хүчин зүйлээс шалтгаалсан байна.

Мал сүргийн зөв бүтцийг бий болгох, бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх, цөлжилтийг бууруулах зорилгоор УИХ-аас 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг баталж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн ч хуулийн хэрэгжилт хангалтгүй, сумдын ИТХ-аас тогтоосон малын тоо толгойн албан татварын хэмжээ нь бэлчээрийн даацын хэтрэлт, бэлчээрийн доройтлоос сэргийлэх хөшүүрэг болж чадахгүй байна.

Цаг, уур орчны шинжилгээний газраас гаргасан Монгол Улсын 2022-2023 оны бэлчээрийн даацыг тодорхойлсон дүн мэдээгээр Монгол Улсын нийт нутгийн 40 орчим хувьд бэлчээрийн даац хүрэлцээтэй, 60 гаруй хувьд бэлчээрийн даац хэтэрсэн байна. Өөрөөр хэлбэл нийт нутгийн 18.4 хувь нь бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн, 7.7 хувь нь даац 3-5 дахин хэтэрсэн, 34.4 хувь нь даац 1-3 дахин хэтэрсэн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 2. 2022-2023 оны өвөл-хаврын бэлчээрийн даацыг тодорхойлсон дүн



Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 -д МТТАТ-ыг ОНХС-ийн эх үүсвэр болгож, бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль

⁸ Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.



орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулахаар хуульчилсан.

Малын тоо толгойн албан татвараас ОНХС-д төвлөрүүлсэн орлогыг хөрөнгө оруулалтын бус, урсгал зардлын шинжтэй арга хэмжээнд зарцуулж байгаа нь сангийн үндсэн зорилгыг алдагдуулж байна.

Иймд Төсвийн тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг УИХ-д толилуулав.

ОНХС-д “Тогтвортой амьжиргаа 3” төслийн урамшууллаар 2023 онд өмнөх жилийн ОНХС-ийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн 21 аймгийн 218 суманд нийт 15,930.5 сая төгрөгийг төлөвлөж, олгосон байна.

ОНХС-ийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг “олон нийтийн оролцоо”, “төлөвлөлт”, “ил тод байдал”, “хэрэгжилт”, “хяналт, шинжилгээ-үнэлгээ”, “өмчлөл” гэсэн 6 бүлгийн үзүүлэлтээр дүгнэдэг бөгөөд 2023 оны үнэлгээний дунджаар Орхон, Говь сүмбэр, Хэнтий, Дархан-Уул, Сүхбаатар аймгууд 82.8-89.3 хувиар үнэлэгдсэн байна. Сумдаас Өвөрхангай аймгийн Хайрхан дулаан сум 95.0 хувь, Хэнтий аймгийн Баян-Овоо сум 94.0 хувь, Төв аймгийн Эрдэнэсант сум 93.0 хувийн үнэлгээг авсан сайн үзүүлэлттэй байна.

Дорнод, Орхон, Төв, Сэлэнгэ, Дорноговь аймгууд 2023 онд хамгийн өндөр дүнтэй урамшууллыг авч ОНХС-ийн эх үүсвэрээ нэмэгдүүлж чаджээ.

Хүснэгт 6. “Тогтвортой амьжиргаа 3” төслийн ЖГҮ-ний дундаж, олгосон санхүүжилт (сая төгрөг)

№	Аймаг	Сумын тоо	2023 оны жилийн гүйцэтгэлийн дундаж үнэлгээ /6 үнэлгээний дунджаар/	Урамшуулал авсан сумын тоо	Урамшуулал авсан сумын эзлэх хувь	“Тогтвортой амьжиргаа 3” төслийн урамшуулал /2022 оны ЖГҮ-нд үндэслэсэн /	Урамшуулал аваагүй сумын тоо
1.	Архангай	19	62.30%	14	73.68%	504.1	5
2.	Баян-Өлгий	13	58.46%	3	23.08%	175.8	10
3.	Баянхонгор	20	66.80%	16	80.00%	957.2	4
4.	Булган	16	71.04%	6	37.50%	255.1	10
5.	Говь-Алтай	18	55.44%	5	27.78%	187.5	13
6.	Дорноговь	14	72.81%	6	42.86%	1,018.8	8
7.	Дорнод	14	77.63%	14	100.00%	1,652.1	0
8.	Дундговь	15	74.69%	13	86.67%	645.4	2
9.	Завхан	24	60.58%	16	66.67%	615.3	8
10.	Өвөрхангай	19	76.34%	19	100.00%	907.5	0
11.	Өмнөговь	15	67.65%	7	46.67%	676.0	8
12.	Сүхбаатар	13	82.54%	8	61.54%	806.6	5
13.	Сэлэнгэ	17	74.92%	12	70.59%	1,102.7	5
14.	Төв	27	81.56%	20	74.07%	1,160.1	7
15.	Увс	19	57.98%	9	47.37%	392.7	10
16.	Ховд	17	64.39%	6	35.29%	652.8	11
17.	Хөвсгөл	23	70.27%	20	86.96%	977.4	3
18.	Хэнтий	18	83.08%	16	88.89%	736.4	2
19.	Дархан-Уул	4	82.82%	3	75.00%	788.3	1
20.	Орхон	2	89.32%	2	100.00%	1,283.0	0
21.	Говьсүмбэр	3	87.31%	3	100.00%	435.7	0
Дүн		330	72.28%	218	66.06%	15,930.5	112

Эх сурвалж: “Тогтвортой амьжиргаа 3” төслийн тайлангаас

“Тогтвортой амьжиргаа 3” төслийн урамшуулалд Дорнод, Өвөрхангай, Орхон, Говьсүмбэр аймгууд бүх сумдаа бүрэн хамруулж чадсан бол Баян-Өлгий, Говь-Алтай аймгууд нийт сумдынхаа 23.1-27.8 хувийг хамруулжээ.



Зарим аймаг, сумд ОНХС-ийн хөрөнгийг эх үүсвэр тус бүрээр бүрэн төлөвлөх талаар санаачилгатай ажиллаагүй байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлттэй холбоотой дараах зөрчил илэрсэн.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймагт татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар ОНХС-ийн эх үүсвэрт 240.0 сая төгрөгийг төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр ОНХС-д төвлөрүүлээгүй.
- ✓ Булган аймагт ОНХС-ийн эх үүсвэрийг орлогын эх үүсвэр тус бүрээр төлөвлөж, бүрдүүлэхэд сумдын засаг дарга нар идэвх санаачилгатай ажиллаагүй.
- ✓ Говь-Алтай аймагт сумдын ИТХ-аар баталсан МТТАТ-ыг 407.7 сая төгрөгөөр зөрүүтэй баталж, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөвт өртгийг эх үүсвэртэй нь уялдуулаагүй.
- ✓ Дархан-Уул аймагт ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд заасан эх үүсвэр тус бүрээр төлөвлөөгүй.
- ✓ Хэнтий аймагт "Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж"-д заасан эх үүсвэрийг судалж, ОНХС-д нэмж төлөвлөөгүй.
- ✓ Төв аймгийн Зуунмод сумын ОНХС-д төвлөрүүлэх МТТАТ-ын орлогыг сумын төсвийн орлогод тооцож, сумын ИТХ-аар батлуулаагүйгээс 34.8 сая төгрөгөөр ОНХС-ийн эх үүсвэрийг дутуу төлөвлөсөн.
- ✓ Дундговь аймагт хууль, журамд заасан нэр төрлөөр нь бодитой төлөвлөөгүй, тухайлбал тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хандив, тусламжийн орлого болон бусад дотоод, гадаадын хандив, тусламжийн орлогыг тооцож төлөвлөөгүй.
- ✓ Сэлэнгэ, Хөвсгөл аймагт жилийн эцсийн малын тоонд үндэслэн МТТАТ-ын орлогыг бодитоор төлөвлөөгүй.
- ✓ Дундговь аймгийн Дэлгэрхангай, Өндөршил сумд 2023 онд "Тогтвортой амьжиргаа-3" төслөөс урамшуулал авах боломжийг алдсан.
- ✓ Завхан аймагт МТТАТ-ын орлогыг 19 сум төлөвлөсөн хэмжээнд бүрдүүлээгүй.
- ✓ Говь-Алтай аймгийн Алтай сум 10.5 сая төгрөг, Бигэр сум 12.9 сая төгрөг, Дарви сум 17.8 сая төгрөг, Жаргалан сум 3.1 сая төгрөг, Төгрөг сум 6.6 сая төгрөг, Халиун сум 13.9 сая төгрөг, Цогт сум 11.5 сая төгрөг, Чандмань сум 9.9 сая төгрөг, Эрдэнэ сум 3.4 сая төгрөг, Есөнбулаг сум 2.9 сая төгрөг нийт 91.9 сая төгрөгийн өвс тэжээлийн үнийг ОНХС-д төвлөрүүлээгүй.
- ✓ Завхан аймгийн Алдархаан сум 5.0 сая төгрөг, Баянтэс сум 3.5 сая төгрөг, Дөрвөлжин сум 7.3 сая төгрөг, Сантмаргаз сум 10.0 сая төгрөг, нийт 25.8 сая төгрөгийн өвс тэжээл борлуулсны орлогыг ОНХС-ийн дансанд төвлөрүүлээгүй.
- ✓ Төв аймгийн Зуунмод сумын МТТАТ-ын орлогын дансанд төвлөрсөн 2022 оны 5.2 сая төгрөг, 2023 оны 16.4 сая төгрөг, нийт 21.6 сая төгрөгийн орлогыг сумын ОНХС-д төвлөрүүлээгүй.
- ✓ Ховд аймагт "Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу хандив тусламжийн санхүүжилтийн тооцоог гэрээлэгч байгууллагатай 4.1 сая төгрөгөөр дутуу тооцоо нийлж, авлагаар тусгаагүй.
- ✓ Дундговь аймагт нийт хандив, тусламжаас 220.0 сая төгрөгийг аймгийн ОНХС-д төвлөрүүлж, 430.0 сая төгрөгийг "Уяхан замбуу тивийн наран" урлаг болон бусад арга хэмжээнд зарцуулжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60.2.5, 60.2.9-д заасныг зөрчиж, орон нутгийн хөгжлийг дэмжихэд зориулан олгогдсон хандив тусламжийг зориулалт бусаар зарцуулагдах эрсдэлийг бий болгосон тул Дундговь аймгийн Засаг даргад ТЕЗ-ийн 2023 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлд аудитаар зөвлөмж хүргүүлсэн байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх зөрчилд нийт 917.4 сая төгрөгийн зөрчилд 149.4 сая төгрөгийн 12 төлбөрийн акт, 268.7 сая төгрөгийн 3 албан шаардлага, 499.3 төгрөгийн 41 зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн байна.

1.2 Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь иргэдийн саналаар дэмжигдээгүй, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталдаг зөрчил давтагдсаар байна



1.2.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог хангах, тухайн хөрөнгө оруулалтын ач холбогдол, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлэх талаар Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1⁹, 63.2¹⁰, 63.3¹¹, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 5¹², 6¹³, 7¹⁴ дугаар зүйлд тус тус заасан байна.

Журамд заасны дагуу сум, дүүргийн Засаг даргаас томилсон ажлын хэсэг, баг, хорооны Засаг дарга нар 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд иргэд олон нийтэд нээлттэй асуулга явуулж, давхардсан тоогоор 2,080,367 иргэнээс санал авчээ.

Дүрслэл 3. Иргэдийн санал өгсөн байдал



Нийт 1,798,022 саналыг цаасаар, 144,483 саналыг цахимаар, 137,862 бүлгийн ярилцлагаар авсан байна. Иргэдээс 16,397 төсөл арга хэмжээнд санал өгснөөс 10,002 санал батлагдаж, 6,480 санал цуцлагдсан байна. (Дэлгэрэнгүйг судалгаа 2-оос харна уу)

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа хангалтгүй, иргэдийн идэвх оролцоо сул байна. Тухайлбал: Аймгуудын ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн санал өгсөн байдлыг хөдөлмөрийн насны хүн амын тоотой харьцуулахад Архангай аймаг нийт хөдөлмөрийн насны иргэдийн 23.0 хувь, Говьсүмбэр аймаг 18.1 хувь, Дархан-Уул аймаг 12.9 хувь, Дорноговь аймаг 18.6 хувь, Орхон аймаг 13.5 хувь, Дундговь аймаг 28.3 хувь, Увс аймаг 30.6 хувь, Хэнтий аймаг 36.3 хувь нь хамрагджээ. Энэ нь сум, багийн түвшинд иргэдээс санал авах ажлыг цаасан баримт бүрдүүлж, нэр төдий хийдэг, багийн ИНХ-ыг хангалтгүй ирцтэйгээр зохион байгуулдаг зэрэг шат, шатны албан тушаалтны ажлын хариуцлага сул, нөгөө талаас ОНХС-ийн талаарх иргэд олон нийтийн мэдлэг, мэдээлэл дутмаг зэрэгтэй холбоотой байна.

Төсвийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлж, орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийн хяналтыг бий болгох зорилгоор ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, саналыг хүртээмжтэй байдлаар авах, цахим болон техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэрийг ашиглан иргэдийн оролцоог хангаж ажиллах зайлшгүй шаардлага үүсэж байна.

ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэд олон нийтийн саналыг цаасан хэлбэрээр авч нэгтгэж байгаа нь иргэдээс хүртээмжтэй байдлаар санал авах ажлыг хязгаарладаг. Харин сүүлийн жилүүдэд цахимаар санал авах (“Тогтвортой амьжиргаа 3” төслийн хүрээнд бий болсон ОНХС гар утасны аппликейшн) ажил тодорхой хэмжээнд хийгдсэнээр, саналын тоо өмнөх жилүүдээс эрс нэмэгдсэн байна.

ОНХС-ийн удирдлага мэдээллийн системийн гар утасны аппликейшнийг иргэд ашиглаж санал өгч байгаа боловч иргэний оруулсан ТАХ-ний нэр бусад иргэдэд харагдахгүйгээс тухайн иргэний

⁹ Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

¹⁰ Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

¹¹ Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

¹² Тав. Баг, хорооны түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх

¹³ Зургаа. Сум, дүүргийн түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх

¹⁴ Долоо. Аймаг, нийслэлийн түвшинд ОНХС-ийн төлөвлөх



санал дэмжигдэхгүй байгаа тул гар утасны аппликейшнд хөгжүүлэлт хийх зөвлөмжийг Сангийн яаманд хүргүүллээ. (Баянхонгор аймгаас туршиж ирүүлсэн санал).

Аудитын явцад иргэд, олон нийтээс гүүгл форум (google forum) ашиглан санал асуулга, судалгааг 21 асуултын хүрээнд 21 аймаг, нийслэлийн нийт 7,694 иргэнээс цахимаар, 361 иргэнээс цаасаар авч нэгтгэсэн.

ОНХС-ийн талаарх мэдлэг, мэдээллийн талаар:



ОНХС-ийн талаар та хэр мэдээлэлтэй байдаг вэ ? гэсэн асуулгад нийт оролцогчдын 52.0 хувь нь “Хангалттай мэдээлэлтэй”, 38.0 хувь нь “Хангалтгүй”, 10.0 хувь нь “Мэдэхгүй” гэж хариулсан байна. Харин **ОНХС-ийн талаарх холбогдох хууль, тогтоомж, журмыг судалж үзсэн үү ?** гэсэн асуултад 55.0 хувь нь “Үгүй”, 45.0 хувь нь “Тийм” гэж хариулсан байна.



ОНХС-ийн мэдээллийг хаанаас авдаг вэ ? гэсэн асуултад оролцогчдын 38.0 хувь нь орон нутгийн мэдээллийн хэрэгслээс, 27.0 хувь нь засаг дарга, баг, хороодын хэсгийн ахлагч нараас, 9.0 хувь нь удирдлага мэдээллийн системээс, 4.0 хувь нь нэг цэгийн үйлчилгээний цэгээс мэдээлэл авдаг гэж хариулсан бол 22.0 хувь нь мэдээлэл авдаггүй гэсэн байна.

ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн идэвх оролцооны талаар:

Та 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-д саналаа өгсөн үү ? гэсэн асуулгад 60.0 хувь нь “Тийм”, 40.0 хувь нь “Үгүй” гэж хариулсан бөгөөд саналаа өгсөн иргэдийн 54.0 нь цахимаар болон апплейкшинээр өгсөн бол 46.0 нь цаасаар өгсөн байна. Харин **Та орон нутгийнхаа 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон төсөл арга хэмжээний талаар мэдэх үү?** гэсэн асуулгад оролцогчдын 29.0 хувь нь “Сайн мэднэ” гэж хариулсан бол 53.0 хувь нь “Зарим төсөл арга хэмжээг мэднэ”, 18.0 хувь нь “Огт мэдэхгүй” гэж хариулсан байна.



Дээрх санал асуулгын дүнгээс оролцогчдын ОНХС-ийн талаарх мэдлэг, мэдээлэл хангалттай биш, иргэдийн ОНХС-д ач холбогдол өгч анхаарал хандуулах идэвх оролцоо сул, нөгөө талаас



хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, мэдээлэл түгээх байдал хангалтгүй, байгааг харуулж байна.

ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3¹⁵ 60.3.6¹⁶ дахь заалт, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.3.2¹⁷ заалтуудтай нийцүүлэн үзэхэд дараах зөрчлүүд илэрчээ.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 5,976.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 ТАХ-нд урьдчилсан саналын жагсаалтыг боловсруулж, иргэд олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж төлөвлөөгүй, Жаргалант сум 175.5 сая төгрөгийн 11, Хайрхан сум 145.5 сая төгрөгийн 5, Цэцэрлэг сум 157.1 сая төгрөгийн 6, Чулуут сум 178.6 сая төгрөгийн 11, Эрдэнэбулган сум 15.0 сая төгрөгийн 2, нийт 6,647.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 67 ТАХ-г иргэдийн саналгүйгээр төлөвлөж баталсан.
- ✓ Баянхонгор: Аймгийн ОНХС 2,855.8 сая төгрөгийн 44, Баян-Овоо сум 490.0 сая төгрөгийн 4, Эрдэнэцогт сум 20.0 сая төгрөгийн 1, Баянхонгор сум 30.6 сая төгрөгийн 4, нийт 3,396.1 сая төгрөгийн 53 ТАХ-г арга хэмжээг иргэдийн саналгүйгээр баталсан.
- ✓ Баян-Өлгий: Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлсэн 548.8 сая төгрөгийн 25 ТАХ, Алтай сум 110.3 сая төгрөгийн 6, Алтанцөгц сум 56.1 сая төгрөгийн 8, Булган сум 106.7 сая төгрөгийн 4, Цагааннуур сум 50.0 сая төгрөгийн 9, Өлгий сумын 610.7 сая төгрөгийн 42, Дэлүүн сум 96.5 сая төгрөгийн 13, нийт сая төгрөгийн 1,579.0 сая төгрөгийн 107 ТАХ иргэдийн саналгүй, эрэмбэлэгдээгүй.
- ✓ Говь-Алтай: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2,637.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 81 ТАХ, Баян-Уул, Бигэр, Дарви, Жаргалан, Тонхил, Төгрөг, Цээл, Чандмань, Эрдэнэ, Есөнбулаг сумд иргэдээс санал аваагүй 1,387.8 сая төгрөгийн 67 ТАХ, нийт 4,024.9 сая төгрөгийн 148 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан.
- ✓ Говьсүмбэр: Аймгийн ОНХС-ийн санхүүжүүлэх 2,024.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ, Сүмбэр сум 598.2 сая төгрөгийн 8, Баянтал сум 30.0 сая төгрөгийн 1, нийт сая төгрөгийн 2,652.2 сая төгрөгийн 22 ТАХ-г иргэдийн санал авч эрэмбэлээгүй ИТХ-аар баталсан.
- ✓ Дархан-Уул: Иргэдийн саналаар дэмжигдээгүй аймгийн ОНХС 10.0 сая төгрөгийн 1, Шарын гол сум 36.3 сая төгрөгийн 5, нийт 46.3 сая төгрөгийн 6 ТАХ-г төлөвлөж баталсан, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй.
- ✓ Дорноговь: Айраг сум 9.6 сая төгрөгийн 1, Даланжаргалан сум 19.7 сая төгрөгийн 1, Хатанбулаг 29.7 сая төгрөгийн 2, Эрдэнэ сум 85.9 сая төгрөгийн 4, нийт 144.4 сая төгрөгийн 8 ТАХ-нд иргэдийн саналыг аваагүй төлөвлөсөн.
- ✓ Дорнод: Баянтүмэн 188.5 сая төгрөгийн 6, Булган 92.2 сая төгрөгийн 4, Цагаан-Овоо 291.8 сая төгрөгийн 2, Баян-Уул 335.4 сая төгрөгийн 15, Баяндун 193.0 сая төгрөгийн 6, Дашбалбар 486.9 сая төгрөгийн 4, Сэргэлэн 55.3 сая төгрөгийн 2, Чулуунхороот 234.0 сая төгрөгийн 11, Гурванзагал 29.6 сая төгрөгийн 4, Чойбалсан 34.0 сая төгрөгийн 3, нийт 1,940.7 сая төгрөгийн 57 ТАХ-г иргэдийн саналгүйгээр төлөвлөж баталсан.
- ✓ Завхан : Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс авах саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй, олон нийтийн оролцоог бүрэн хангаж ажиллаагүй байна (/22 суманд).
- ✓ Орхон: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө журамд заасны дагуу урьдчилсан жагсаалт боловсруулж, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй, аймгийн төвийн Баян-Өндөр сумын авсан иргэдийн саналыг харгалзан аймгийн орон нутгийн төсөв боловсруулах үйл явцтай хамт төлөвлөсөн.
- ✓ Өвөрхангай: Иргэдийн саналд тусгагдаагүй аймгийн ОНХС-аар 3,741.2 сая төгрөгийн 27, Баян-Өндөр сум 35.7 сая төгрөгийн 2, нийт 3,776.9 сая төгрөгийн 29 ТАХ-г төлөвлөж, хэрэгжүүлсэн.

¹⁵ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно:

¹⁶ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

¹⁷ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;



- ✓ Өмнөговь: Иргэдээс санал авч эрэмбэлсэн жагсаалтад ороогүй Мандал-Овоо сум 135.0 сая төгрөгийн 3, Ханбогд сум 1,865.8 сая төгрөгийн 2, Хүрмэн сум 4.2 сая төгрөгийн 1, нийт 2,004.9 сая төгрөгийн 6 ТАХ-г төлөвлөж, баталсан байна.
- ✓ Сэлэнгэ: Аймгийн ОНХС иргэдийн саналыг авч, эрэмбэлэгдээгүй 1,280.4 сая төгрөгийн 9, Алтанбулаг сум 350.0 сая төгрөгийн 2, Баруунбүрэн сум 130.0 сая төгрөгийн 4, Зүүнбүрэн сум 20.0 сая төгрөгийн 1, Орхонтуул сум 115.0 сая төгрөгийн 5, нийт 1,895.4 сая төгрөгийн 21 ТАХ-г төлөвлөж, баталсан байна.
- ✓ Төв: Аймаг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 13,562.9 сая төгрөгийн 86 ТАХ-нд урьдчилсан саналын жагсаалтыг боловсруулж, иргэд олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж төлөвлөөгүй
- ✓ Увс: Бөхмөрөн сум 284.4 сая төгрөгийн 12, Наранбулаг сум 638.5 сая төгрөгийн 29, нийт 922.9 сая төгрөгийн 41 ТАХ нь иргэдээс санал авч эрэмбэлэгдээгүй.
- ✓ Хөвсгөл: Тариалан сум 92.0 сая төгрөгийн 6, Тосонцэнгэл сум 70.0 сая төгрөгийн 6, нийт 162.0 сая төгрөгийн 12 ТАХ-г иргэдээс санал авч эрэмбэлээгүй баталсан.
- ✓ Хэнтий: Аймгийн ОНХС 373.9 сая төгрөгийн 3, Баянхутаг сум 15.0 сая төгрөгийн 3, нийт 388.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй 6 ТАХ-г аймаг, сумын ИТХ-аар баталж, хэрэгжүүлсэн байна.
- ✓ Нийслэл: ОНХС-ийн үйл ажиллагааны журмын дагуу ажлын хэсэг байгуулаагүй, иргэдийн саналыг эрэмбэлээгүй, үр ашгийн тооцоолол хийгээгүй байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх зөрчлүүдэд 15,141.9 сая төгрөгийн 53 албан шаардлага, 13,771.2 төгрөгийн 36 зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн байна.

Аудитаар иргэдийн саналгүй 28,913.1 сая төгрөгийн 806 төсөл арга хэмжээг төлөвлөсөн зөрчил илэрсний 22,373.0 сая төгрөгийн 428 төсөл, арга хэмжээ нь 12 аймгийн ОНХС, 6,540.1 сая төгрөгийн 378 төсөл арга хэмжээ нь 76 сумын ОНХС-ийн төлөвлөлттэй холбоотой байна.

Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчид нь олонхын саналаар ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн саналаар дэмжигдээгүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн зөрчил бүрэн арилахгүй давтагдсаар байна.

Иргэдийн саналаар дэмжигдээгүй 806 төсөл, арга хэмжээ нь нийт батлагдсан төсөл, арга хэмжээний 7.8 хувь, аудитаар илэрсэн нийт зөрчлийн 17.8 хувийг эзэлж байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь ОНХС-ийн төсвийг хууль тогтоомжийг зөрчин баталж байгаад чиглэсэн хариуцлага тооцох тогтолцоо бүрдээгүй асуудлыг УИХ-д толилууллаа.

1.2.2 Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9¹⁸, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2¹⁹, 63.3²⁰, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.1²¹, 4.1.3²²-т заасныг үндэслэн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймаг, нийслэл, сум дүүрэг нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулж төлөвлөлтийг хийхээр хуульчилсан.

Улсын хэмжээнд 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан 10,330 төсөл, арга хэмжээний 107 буюу 1.0 хувь нь аймаг, сум, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй байна.

¹⁸ Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна.

¹⁹ Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

²⁰ Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн ажлын алба ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлд өргөн мэдүүлнэ.

²¹ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

²² ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх;



Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай: Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлэх 529.8 сая төгрөгийн 8 ТАХ нь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, орон нутгийн бодлого чиглэлтэй уялдаагүй, ТАХ-г хэт жижиглэж, төсөвт байгууллагын урсгал зардалд зарцуулж байгаа нь орон нутгийн хөгжлийг дэмжихгүй байна.
- ✓ Говь-Алтай: Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлэх 31, Алтай, Баян-Уул, Бигэр, Дэлгэр, Жаргалан, Төгрөг, Цээл, Чандмань, Эрдэнэ, Есөнбулаг сумдын 49 ТАХ нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй.
- ✓ Говьсүмбэр: Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлэх 3, Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдын 7 ТАХ нь Аймгийн Засаг даргын “2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон сумдын “2021- 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдаагүй
- ✓ Ховд: Цэцэг,Чандмань, Алтай, Мянгад,Мөст,Үенч сумд нийт 105.1 сая төгрөгийн 9 ТАХ-г аймаг, сум, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулж төлөвлөөгүй.
- ✓ Сэлэнгэ: 12 сум нь иргэдийн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ орон нутгийн хөгжлийн бодлого, чиглэлтэй уялдсан эсэхийг харгалзаж үзээгүй, төсөл арга хэмжээний жагсаалтыг журмын дагуу бэлтгээгүй байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх зөрчлүүдэд нийт 634.9 сая төгрөгийн зөрчилд 529.8 сая төгрөгийн 1 албан шаардлага, 105.1 сая төгрөгийн 19 зөвлөмжийг шалгаагдагч байгууллагуудад хүргүүлсэн байна.

1.2.3 Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжих төсөл, арга хэмжээг ИТХ-д өргөн барьж, батлуулахдаа тухайн шатны Засаг дарга төсөвлөлтийн шаардлагыг хангуулж техник эдийн засгийн үндэслэл зураг, төсөв, эдийн засгийн тооцоо судалгааг хийсэн байх үүрэгтэй.

Гэвч хууль, журамд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйгээс 21,450.0 сая төгрөгийн 1,503 төсөл арга хэмжээг шат, шатны ИТХ-аар баталсан байна. ОНХС-ийн аудитаар Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 ²³, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3.3, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.3²⁴ дахь заалтын хүрээнд дараах зөрчлүүд илэрсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймгийн ОНХС-аар хэрэгжүүлэх 31, сумдын 346.5 сая төгрөгийн 43, Баянхонгор сум 20.0 сая төгрөгийн 1, Говь-Алтай аймаг, сумдын 4,615.5 сая төгрөгийн 296, Говьсүмбэр аймаг, сумдын 1,581.0 сая төгрөгийн 17, Дорноговь аймаг, сумдын 327.6 сая төгрөгийн 27, Завхан аймаг, сумдын 6,419.2 сая төгрөгийн 482, Орхон аймаг 245.0 сая төгрөгийн 1, Сүхбаатар аймаг, сумдын 1,795.4 сая төгрөгийн 17, Хөвсгөл аймаг, сумдын 3,441.4 сая төгрөгийн 31, нийслэлийн 9,408.3 сая төгрөгийн 32 ТАХ нь эдийн засгийн тооцоолол, зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй, Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгуурыг хангаагүй байна.
- ✓ Булган аймаг, сумдын түвшинд 465 ТАХ-нд урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан харьцааг тодорхойлоогүй, ТАХ-г хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт гаргаагүй, төлөвлөсөн зорилтод түвшний үр дүнг бодитой гаргаагүй.
- ✓ Сүхбаатар аймаг тоног төхөөрөмжийн ТАХ-ий төсөвт өртгийг тодорхойлохдоо мэргэжлийн байгууллагын хийсэн зах зээлийн үнийн судалгаа, дүгнэлт, тайланд үндэслээгүй, зураг төсвийн магадлалын дүгнэлт гараагүй байхад төсөвт тусгаж, батлуулсан.
- ✓ Сэлэнгэ аймаг зураг төсөв, урьдчилсан тооцоо судалгаагүй 5,820.1 сая төгрөгийн 59 ТАХ-г ИТХ-аар батлуулсан, Мандал сум 208.6 сая төгрөгийн ТАХ-г бөөн дүнгээр батлуулсан.

²³ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

²⁴ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх



- ✓ Ховд аймаг Монгол хэл бичиг дэд хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийлгэхдээ ажлын туршлагагүй, мэргэжлийн бус төрийн бус байгууллага сонгож, 15.7 сая төгрөгийг олгосон. Тус ажилд сонгон шалгаруулалт зарлаагүй, хөндлөнгийн үнэлгээ хийсэн эсэх нь тодорхойгүй, ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүй байна.
- ✓ Баян-Өлгий аймаг баяр наадмын зардлыг жишиг нормоос 4.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан
- ✓ Говь-Алтай аймаг ИТХ-аар батлагдаагүй 6.1 сая төгрөгийн 3 ТАХ-г хэрэгжүүлж, ИТХ-аар баталсан 126 ТАХ хэрэгжээгүй байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх нийт 21,450.0 сая төгрөгийн зөрчилд 14,785.8 сая төгрөгийн 37 албан шаардлага, 6,664.2 сая төгрөгийн 68 зөвлөмжийг шалгадагч байгууллагуудад хүргүүлсэн байна.

1.2.4 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2²⁵-т аймаг, нийслэлийн түвшинд, 4.4²⁶, 4.5²⁷-т сум, дүүргийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүргийг тус тус заасан.

Улсын хэмжээнд 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр 544,390.0 мянган төгрөгийн 10,330 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр шат, шатны ИТХ-аар баталж, гүйцэтгэлээр 8,672 төсөл, арга хэмжээнд 408,507.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

ОНХС-аар 2023 онд хэрэгжүүлсэн 8,672 төсөл хэмжээний 1,372 буюу 15.8 хувийг аймаг, нийслэлийн түвшинд, 7,300 төсөл арга хэмжээ буюу 84.2 хувийг сум, дүүргийн түвшин хэрэгжүүлжээ.

Аймаг, нийслэлийн түвшинд 1,372 төсөл арга хэмжээнд 204,129.0 сая төгрөг зарцуулсныг журмын дагуу ангилан авч үзвэл:

Дүрслэл 8. Аймаг, нийслэлийн чиг үүрэг хувиар:



- ✓ “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэн ухаан, цахим технологи” чиг үүргийн хүрээнд 412 ТАХ-нд 38,195.6 сая төгрөг
- ✓ “Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ” чиг үүргийн хүрээнд 369 ТАХ-нд 98,532.3 сая төгрөг
- ✓ “Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах” чиг үүргийн хүрээнд 339 ТАХ-нд 40,145.1 сая төгрөг
- ✓ “Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах” чиг үүргийн хүрээнд 108 ТАХ-нд 8,661.3 сая төгрөг
- ✓ “Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах” чиг үүрэгт 60 ТАХ-нд 6,482.7 сая төгрөг
- ✓ “Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх” чиг үүрэгт 3,311.5 сая төгрөгийн 40 ТАХ
- ✓ “Өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт” чиг үүргийн хүрээнд 17 ТАХ-нд 1,533.8 сая төгрөг
- ✓ Журамд заасан чиг үүрэгт хамааралгүй 3,021.1 сая төгрөгийн 10 ТАХ байна. (Дэлгэрэнгүйг судалгаа 3-аас харна уу)

Харин сум, дүүргийн түвшинд 7,300 төсөл арга хэмжээнд 204,378.7 сая төгрөг зарцуулсныг журмын дагуу ангилан авч үзвэл:

²⁵ Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

²⁶ Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

²⁷ Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.



Дүрслэл 9. Сум, дүүргийн чиг үүрэг хувиар



- ✓ “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэн ухаан, цахим технологи” чиг үүргийн хүрээнд 1,539 ТАХ-нд 40,320.5 сая төгрөг
- ✓ “Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ” чиг үүргийн хүрээнд 1,385 ТАХ-нд 56,617.1 сая төгрөг
- ✓ “Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах” чиг үүргийн хүрээнд 1,750 ТАХ-нд 57,849.4 сая төгрөг
- ✓ МТТАТ-ын орлогоос чиг үүргийн дагуу 1,529 ТАХ-нд 23,030.1 сая төгрөг
- ✓ “Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах” чиг үүргийн хүрээнд 286 ТАХ-нд 4,939.9 сая төгрөг
- ✓ “Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах” чиг үүргийн хүрээнд 411 ТАХ-нд 10,997.4 сая төгрөг
- ✓ “Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх” чиг үүргийн хүрээнд 167 ТАХ-нд 3,343.4 сая төгрөг
- ✓ “Өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт” чиг үүргийн хүрээнд 44 ТАХ-нд 1,250.8 сая төгрөг
- ✓ “Ажлын байр бий болгох” чиг үүргийн хүрээнд 71 ТАХ-нд 4,024.6 сая төгрөг
- ✓ Журамд заасан чиг үүрэгт хамааралгүй 2,005.4 сая төгрөгийн 118 ТАХ байна. (Дэлгэрэнгүйг судалгаа 4-өөс харна уу)

“ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-д заасан чиг үүрэгт нийцээгүй ТАХ-г хэрэгжүүлсэн дараах зөрчил илэрсэн.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Баянхонгор аймгийн ОНХС-ийн 270.0 сая төгрөгийн 1, Баян-Овоо сумын 10.0 сая төгрөгийн 1, Булган аймгийн Сэлэнгэ сум 2.3 сая төгрөгийн 1, Говь-Алтай аймаг 2,541.7 сая төгрөгийн 7, 14 сумын 548.3 сая төгрөгийн 15, Говь сүмбэр аймаг 3 сум 468.6 сая төгрөгийн 7, Дорнод аймаг 7 сумын 111.0 сая төгрөгийн 7, Завхан аймаг 9 сумын 201.2 сая төгрөгийн 25, Сэлэнгэ аймаг 2 сум 101.7 сая төгрөгийн 2, Ховд аймаг 267.5 сая төгрөгийн 1, Хэнтий аймаг 2 сум 179.4 сая төгрөгийн 4 ТАХ байна.
- ✓ Сүхбаатар аймгийн 14 сумын ОНХС-ийн хөрөнгөөр ажлын байр бий болгох, нэмэгдүүлэх чиглэлээр ажил төлөвлөж, хэрэгжүүлээгүй.
- ✓ Ховд аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрийн санхүүжилтийг хөтөлбөр тус бүрээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд үндэслэн төлөвлөөгүй, бөөн дүнгээр хөтөлбөр хэрэгжүүлэх гэж баталсан нь хэрэгжилт хангагдахгүй, зориулалтын дагуу зарцуулахгүй байх нөхцөл үүссэн байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх нийт 1,032.1 сая төгрөгийн зөрчилд 14.6 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 1,017.5 сая төгрөгийн 26 албан шаардлага, 28 зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн байна.



БҮЛЭГ 2. ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ УРСГАЛ ШИНЖТЭЙ ЗАРДАЛД ЗАРЦУУЛЖ БАЙГАА НЬ ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ БАЙНА

2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөвт өртгийг хэт жижиглэснээс тендер оролцогчгүй болох, оройтох, ажил он дамнах төсөл арга хэмжээний гүйцэтгэл, чанарт сөргөөр нөлөөлж байна

2.1.1 Улсын хэмжээнд 2023 онд шинээр нийт 460,469.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8,241 төсөл, арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Тендер зохион байгуулсан нийт ажлын 11.7 хувь буюу 254,450.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 965 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтаар, 18.5 хувь буюу 79,189.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1527 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар, 37.9 хувь буюу 53,826.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3127 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулах аргаар, 3.4 хувь буюу 4,791.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 281 төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой худалдан авалтаар, 0.1 хувь буюу 894.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл, арга хэмжээг хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар, 28.3 хувь буюу 67,318.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2,331 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна. *(Дэлгэрэнгүйг судалгаа 5-аас харна уу)*

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжаар томилогдсон зарим үнэлгээний хороо нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ болон Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд, МУЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг зөрчсөн байна. Үүний 73.2 хувь нь үнэлгээний хороо, ажлын хэсэг холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймгийн Цахир сумын Засаг дарга нь ЗДТГ-ын няравтай шууд гэрээ байгуулж баяр наадмын зардалд 20.0 сая төгрөгийг зарцуулсан.
- ✓ Баянхонгор аймгийн Богд сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх нийт 91.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-ний төсөвт өртгийг жижиглэн иргэдтэй шууд гэрээ байгуулсан.
- ✓ Говь-Алтай аймгийн Бигэр, Алтай, Бигэр, Чандмань, Есөнбулаг сумд 522.6 сая төгрөгийн 27 ТАХ-нд шууд худалдан авалт хийсэн,
- ✓ Дорнод аймаг Худалдан авах ажиллагааг зарлахдаа босго үнийн журмыг баримтлаагүй, ТАХ-ний төсөвт өртгийг 2 хувааж тендер зарласан.
- ✓ Дундговь аймгийн Эрдэнэдалай суманд 51.6 сая төгрөгийн 2 ТАХ-г, Сайнцагаан сум 40.0 сая төгрөгийн 1 ТАХ-г багцад хуваан баталж, худалдан авах ажиллагаанд босго үнийг мөрдөлгүй шууд гэрээ байгуулсан.
- ✓ Орхон аймгийн Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалтад болзошгүй аваарын зардалд 209.0 сая төгрөг баталж, шууд худалдан авалтаар нийт 12 ажилд хувааж, 204.8 сая төгрөг зарцуулсан.
- ✓ Өвөрхангай аймгийн Баянгол суманд 82.5 сая төгрөгийн ижил төрлийн 5 ТАХ, Нарийн тээл сум 27.0 сая төгрөгийн 1 ТАХ-нд шууд худалдан авалт хийсэн.
- ✓ Сэлэнгэ аймгийн Сайхан, Шаамар, Орхонтуул сумд нийт 147.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ижил төстэй төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 2-3 хуваан төлөвлөж, шууд худалдан авалт хийсэн.
- ✓ Ховд аймгийн Мөст суманд 57.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хужирт багт гүүрэн гарам барих ажил, Мал эмнэлгийн 100 жилийн ойн гарын бэлэг, хэвлэлийн зардалд зарцуулсан, Мал эмнэлгийн хашаа бариулах ажлуудын тендерийг хэсэгчлэн 3 хувааж шууд гэрээ байгуулсан, Жаргалант сум хогны менежментийг хэрэгжүүлэх 1,027.0 сая төгрөгийн ажлыг сумын онцгой



комиссын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн №03 тоот тогтоол гаргуулан шууд гэрээ байгуулсан,

- ✓ Баянхонгор 105.0 сая төгрөгийн 3, Дархан-Уул 29.0 сая төгрөгийн 6, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Орхон, Нийслэл тус бүр 1 нийт 134.0 сая төгрөгийн 14 ТАХ-нд тендерийн баримт бичгийн шаардлага хангаагүй оролцогчийг үнэлгээний хороо, ажлын хэсгийн гишүүд сонгон шалгаруулсан.
- ✓ Баянхонгор 66.8 сая төгрөгийн 1, Сэлэнгэ 204.2 сая төгрөгийн 1, Ховд 354.6 сая төгрөгийн 1, Дархан-Уул, Дорнод, Өмнөговь, Хөвсгөл тус бүр 1 нийт 625.6 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээний тендерийн баримт бичгийг архивлан хадгалаагүй, зарим тендерийн шаардлага хангасан эсэхийг нотлох баримтын бүрдэл дутуу. Баянхонгор аймгийн Баян-Овоо сум ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний тендерийн баримт материалыг аудитын явцад ирүүлээгүй.
- ✓ Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудад нийт 39.5 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээний чанарын баталгаат хугацааны барьцааны талаар гэрээний тусгай нөхцөлд тусгаагүй, тусгасан ч барьцааг авч үлдээгүй.
- ✓ Дархан-Уул 1, Дорнод 13 ТАХ-ний худалдан авах ажиллагааны үр дүнг цахим системд дэлгэрэнгүй мэдээлээгүй, Өвөрхангай 5 төсөл арга хэмжээний нээлттэй тендерийн урилгыг өдөр тутмын сонинд нийтлээгүй.

Шийдвэрлэлт: Худалдан авах ажиллагаатай холбоотой дээрх нийт 2,396.8 сая төгрөгийн зөрчилд 1,595.4 сая төгрөгийн 14, хариуцлага тооцох 69.8 сая төгрөгийн 5 албан шаардлага, 731.6 сая төгрөгийн 75 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Харин худалдан авах ажиллагаанд ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлжээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөвт өртгийг хэт жижиглэснээс бага төсөвтэй төсөл арга хэмжээний тендерт оролцогч ирэхгүй тендер оройтох, ажил он дамнах, ажил гүйцэтгэгч нь ажлын дадлага туршлагагүй, мэргэжлийн боловсон хүчин, ажиллах хүчний нөөцгүй зэрэг нь төсөл арга хэмжээний гүйцэтгэл, чанарт сөргөөр нөлөөлж байна.

Цаашид аймаг, сумын орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан томоохон, хөрөнгө оруулалтын шинж чанартай, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр үр нөлөөтэй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

2.1.2 Улсын хэмжээнд 2023 онд 8,672 төсөл арга хэмжээнд 408,507.6 сая төгрөгийн санхүүжилт олгосны 90.5 хувь буюу 7,847 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 9.5 хувь буюу 825 төсөл арга хэмжээ хэрэгжих шатанд байна. (Дэлгэрэнгүйг судалгаа 6-аас харна уу.)

ОНХС-ийн эх үүсвэрийн малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт 7,532.4 сая төгрөгөөр тасарсан, зарласан тендерт оролцогч ирээгүйгээс худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон, оройтсон, төсөвт өртөг хүрэлцээгүй зэргээс шалтгаалан 1,658 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Хүснэгт 7. ОНХС-ийн 2023 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ

(сая төгрөгөөр)

Аймгийн нэр	ИТХ-аар батлагдсан ХО, хөтөлбөр, ТАХ-ний		Гэрээ байгуулсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Бүрэн хэрэгжсэн ТАХ-ний		Дутуу хэрэгжсэн ТАХ-ний		Огт хэрэгжээгүй ТАХ-ний	
	тоо	Гэрээний дүн	тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Дүн
Аймаг	9938	483,438.3	8385	466,102.0	7646	358,753.7	739	107,348.2	1553	69,482.8
Нийслэл	392	60,951.8	287	55,762.4	201	30,402.1	86	25,360.3	105	10,432.8
Нийт	10330	544,390.0	8672	521,864.4	7847	389,155.8	825	132,708.5	1658	79,915.6

(Дэлгэрэнгүйг судалгаа 6-аас харна уу)

ОНХС-ийн санхүүжилтийг төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй, зориулалт бус зарцуулдаг зөрчил давтагдан гарсаар байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн



16.5.5²⁸, 41 дүгээр зүйлийн 41.2.2²⁹ Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 8.5³⁰, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.12³¹ дахь заалт, гүйцэтгэгч захиалагчийн хооронд байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүйтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Гэрээний алданги тооцоогүй ТАХ-ний тухайд:

- ✓ Булган аймгийн Хутаг-Өндөр сум Наадмын талбай барих, Соёлын төвийн их засвар, Мал тарилгын хашаа, Сайхан сумын төвд гэрэлтүүлэг хийх, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Наадмын талбайн зураг төсөв, гэрэлтүүлэг, Худалдааны захад саравч барих, Зоригч тээврийн зогсоол барих зэрэг ажлууд гэрээт хугацаанаас 25-60 хоног хугацаа хэтэрсэнд 15.9 сая төгрөгийн гэрээний алданги тооцоогүй.
- ✓ Сэлэнгэ аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 10 төсөл, арга хэмжээнд 9.3 сая төгрөгийн гэрээний алданги тооцоогүй санхүүжилтийг бүрэн олгосон.
- ✓ Ховд аймгийн Цэцэг суманд худаг барих ажлын даалгавар, тоо хэмжээг өөрчлөхдөө төсөв хийгээгүй, Улаан үзүүрийн худгийн барилга барих, худаг гаргах ажлын гэрээний хугацааг 2024 оны 04 сарын 24-нийг хүртэл сунгасан, мод усалгааны худгийг гэрээт хүлээлгэж өгөөгүй зэрэг зөрчилд 52.8 сая төгрөгийн алданги тооцоогүй.
- ✓ Хэнтий аймгийн Биндэр, Бор-Өндөр суманд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 11 төсөл, арга хэмжээнд 27.1 сая төгрөгийн гэрээний алданги тооцоогүй.

Чанаргүй буюу дутуу гүйцэтгэлтэй ТАХ-ний тухайд:

- ✓ Баянхонгор Өлзийт сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн Гудамж талбайн гэрэлтүүлгийн ажлыг техникийн тодорхойлолттой тулган шалгахад "Орох хаалгыг тохижуулан 2 талд 6 ширхэг гоёлын мод байх", "гэрэлтүүлгийн баганыг 4 метрийн хоорондын зайтай 11 ширхэг, өндөр 5 м, өргөн 25 метрийн хэмжээтэй 75 трубогор хийсэн 11 ширхэг багана байна" гэснийг хийгээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, зөөврийн бие засах газрын техникийн тодорхойлолтод заасан эрэгтэй, эмэгтэй тасалгаанд тус бүр 1 ширхэг гар угаалтуур байхаар заасан байхад 1 угаалтуурыг байршуулаагүй, замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулан гэрлэн чимэглэл хийх ажлын техникийн тодорхойлолтод заасан ажлаас засмал замын хажуу 20 ширхэг гэрэлтүүлгийн шонг 4 метрийн урттай урсдаг гэрлээр чимэглэх, доод талыг нь фосфортой наалтаар наах ажлыг хийж гүйцэтгээгүй, Нарийн ногоон өвс бэлтгэн нийлүүлэх гэрээг Баян-Овоо сумын Засаг дарга, "Пэйс Роуд" ХХК-ийн захирал нар 2023.01.18-ны өдөр байгуулж, 2142 боодол өвсийг 2023.04.01-ний дотор нийлүүлэхээр гэрээнд тусгаж, 36.4 сая төгрөгийг шилжүүлсэн бөгөөд 1330 боодол өвсийг нийлүүлээгүй, "Ахмадын цэцэрлэгт хүрээлэн, сүүдрэвчтэй болгох ажлыг 49.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр "Мөнх ган оюу" ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд техникийн тодорхойлолтод тусгагдсан орцны шатны налуу гаргах 8 ширхэг, орцны өрлөг, засвар хийх 1 ширхэг, явган замын хашлага, худгийн таг 5 ширхэг, гадна гэрэлтүүлэг 6 ширхэг, модон сандал 10 ширхэг, гацуур модны суулгац 20 ширхэг зэрэг ажлууд хийгдээгүй, Хүүхдийн Тэмүжин театрт 300 ширхэг сандал нийлүүлэх ажлаас 7.8 сая төгрөгийн 50 ширхэг сандлыг нийлүүлээгүй.
- ✓ Баян-Өлгий аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр "Еба констракшн" ХХК-аар гүйцэтгүүлсэн гэрээний 34.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Булган сумын цэцэрлэгийн дээврийн засварын ажлыг дуусгасан гэх боловч ажлын хэсэг томилоогүй, гэрээ дүгнээгүй, барилга, байгууламжийг ашиглалтад хүлээж аваагүй, Баяннуур сумын Цэцэгт багийн бага сургуулийн 249.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй өргөтгөлийн ажлыг хүлээж авах комисс нь ашиглалтад аваагүй.

²⁸ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

²⁹ Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах

³⁰ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно

³¹ "Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно",



- ✓ Дорнод аймаг нийт 2,390.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ-ний гүйцэтгэл чанаргүй, дутуу хийгдсэн.
- ✓ Завхан аймгийн Тосонцэнгэл суманд 25.7 сая төгрөгийг 2 ТАХ, Тэс суманд 30.9 сая төгрөгийн 3 ТАХ, Отгон суманд 29.0 сая төгрөгийн 3 ТАХ, Эрдэнэхайрхан суманд 26.6 сая төгрөгийн 3 ТАХ, Баянтэс, Алдархаан, Их-Уул, Идэр, Сантмаргаз, Цэцэн-Уул, Ургамал сумдад тус бүр 1 ТАХ, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 95.8 сая төгрөгийн 2 ТАХ чанаргүй, ажлын гүйцэтгэл дутуу хийгдсэн.
- ✓ Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын “Хүүхдийн тоглоомын талбай” барих 85.0 сая төгрөгийн тендерт Жоди прожект ХХК нь шалгарч, гүйцэтгэсэн боловч 1 ширхэг сандал, 2 ширхэг хогийн сав, 1 ширхэг хүүхдийн тоглоом, явган замын бордуур зэрэг ажлыг дутуу хийсэн.
- ✓ Ховд аймгийн ОНХС-ийн авлага өмнө оноос 3,376.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, 8 ТАХ-г хугацаанд нь дуусгах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, Эрдэнэбүрэн сумын Тохижилтын ажилд 20.8 сая төгрөг баталж, 15.0 сая төгрөгийг зарцуулсан боловч тухайн ажил хийгдээгүй.
- ✓ Хөвсгөл аймгийн Мөрөн суманд хийгдсэн Ухаалаг худгийн тохижилтын ажлын зураг төсөвт заасан Долоогоно мод 3 ширхэг, Агч мод 3 ширхэг, Нарс мод 6 ширхэг, нийт 12 ширхэг модыг суулгаагүй, "9,11,12-р баг хөгжлийн төвийн урд байрлах хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажлын даалгаварт заасан, талбайн тэмдэг тэмдэглэгээг хийгдээгүй, талбайн хажууд 2 ширхэг хогийн сав байршуулаагүй.

Гэрээ дүгнээгүй, ажлын бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгоогүй ТАХ-ний тухайд:

- ✓ Архангай аймгийн Цахир сум 310.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ, Тариат сум 53.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ, Ихтамир сум 19.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-ний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Ус цаг уур, орчны шинжилгээний төв”-ийн конторын барилгын засвар, өргөтгөлийн барилгын зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчтэй 20.0 сая төгрөгийн өртөгтэй гэрээ байгуулсан ч гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй байхад 18.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.
- ✓ Баянхонгор аймгийн Баян-Овоо суманд 69.8 сая төгрөгийн 3 ТАХ, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 21.3 сая төгрөгийн 3 ТАХ-ний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон.
- ✓ Говь-Алтай аймаг гүйцэтгэгчид санхүүжилт олгохдоо төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлийг үндэслээгүй, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээнд санхүүжилтийг үе шаттай олгохоор тусгалгүйгээр урьдчилж бүрэн олгосон.
- ✓ Говьсүмбэр аймаг нийт 244.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ажлын санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагаас санхүүжилт хүссэн албан бичиг, ажлын гүйцэтгэлийн баримт бичиг болон тендерийн баримт бичигт заасан урьдчилгаа төлбөрийн нөхцөл, ажлын бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй, Сүмбэр сум нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийн засвар шинэчлэлтийн ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэж олгоогүй.
- ✓ Дархан-Уул аймаг ажил гүйцэтгэх гэрээнд заасан чанарын баталгааг суутгалгүй санхүүжилтийг бүрэн олгосон.
- ✓ Завхан аймгийн Баянхайрхан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэнээр тайлагнагдсан 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сайн усны гол дээр гүүр барих”, 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шургуугийн гол дээр гүүр барих” ажлуудыг аудитын явцад газар дээр нь үзэж, холбогдох албан тушаалтнаас тайлбар тодруулга авч, зарцуулалтын анхан шатны баримтыг шалгахад залилангийн эрсдэлтэй, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй, Мөн Иргэний танхим тохижуулах 19.0 сая төгрөгийн ажлыг “Эхлэл шинэчлэлт прожект” ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, санхүүжилт бүрэн шилжүүлснээс хойш 8 сарын дараа нийлүүлэгдсэн бөгөөд зах зээлийн үнээс хэт өндөр, залилангийн эрсдэлтэй байж болзошгүй байна.
- ✓ Сүхбаатар аймаг банкны баталгаагүйгээр 14 ТАХ-ний 335.9 сая төгрөгийн санхүүжилтийг урьдчилж олгосон.
- ✓ Сэлэнгэ аймгийн Хушаат, Сүхбаатар, Баруунбүрэн сум нийт 832.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-ний чанарын баталгаа болох 33.8 сая төгрөгийг “Хөрөнгө оруулалтын барьцаа” дансанд байршуулаагүй, Хурлын тэмдэглэл болон тооцсон төсөвгүйгээр 13 төсөл, арга хэмжээний магадалшгүй ажлын зардалд 52.9 сая төгрөг олгосон.



- ✓ Төв аймгийн Батсүмбэр сум 2023 оны хөрөнгө оруулалтын зураг төсөв гэж батлагдсан 30.0 сая төгрөгөөс ЗДТГ-ын засварын зураг төсөв 4.0 сая төгрөгөөр хийлгэх гэрээ байгуулж 2.0 сая төгрөг шилжүүлсэн, аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 130.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй.
- ✓ Хөвсгөл аймгийн Мөрөн сум Эрдмийн далай цогцолбор сургуулиас Номын өргөө дэлгүүр хүртэл гэрэлтүүлэг, явган замын тохижилтын ажил нь зураг төсөвт заагдсан хэмжээнээс 179 м2 дутуу хийгдсэн байхад ажлыг хүлээж авч, санхүүжилтийг бүрэн олгосон.

Гэрээний үнийн дүнгээс илүү санхүүжүүлсэн ТАХ-ний тухайд:

- ✓ Баянхонгор аймаг "Нийтийн эзэмшлийн талбайд эко 00 нэмэгдүүлэх" ажлын гүйцэтгэлд 0.4 сая төгрөг, "Камержуулалт"-ын ажилд 3.5 сая төгрөг нийт 3.8 сая төгрөгийг гүйцэтгэгчид илүү олгосон.
- ✓ Булган аймгийн Хутаг-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр тайлант онд 60,609.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний магадалшгүй ажлын зардал 1.1 сая, зохиогчийн хяналтын зардал 0.5 сая, захиалагчийн хяналтын зардал 1.1 сая нийт 2.7 сая төгрөгийг гүйцэтгэгч илүү олгосон.
- ✓ Говь-Алтай аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1 ТАХ-ний санхүүжилтийг олгохдоо гэрээний үнийн дүнгээс 2.5 сая төгрөгөөр илүү олгосон.
- ✓ Өмнөговь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Зураг төсвийн багц" ажлын санхүүжилтийг олгохдоо гэрээний үнийн дүнгээс 20.0 сая төгрөгөөр илүү шилжүүлсэн.
- ✓ Сэлэнгэ аймгийн Хушаат сум 81.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Цэцэрлэгт хүрээлэн тохижуулах" төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид 0.4 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон.
- ✓ Төв аймаг 5 ТАХ-ний санхүүжилтийг олгохдоо гэрээний үнийн дүнгээс нийт 23.6 сая төгрөгөөр илүү санхүүжүүлсэн.
- ✓ Ховд аймгийн ОНХС-ийн эцсийн гүйцэтгэлийг тооцож буй ХОХБТХ-ийн мэргэжилтэн, албан тушаалтнууд төсөвт тусгагдсан зохиогчийн хяналтын зардлыг тооцож аваагүй,
- ✓ Хөвсгөл аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн "Цагаан-Уул Могойн голын 35кВ-ын ЦДАШ-н засвар арчлалт" ажлын санхүүжилтийг "Бошголсон" ХХК-д бүрэн олгосон байхад Хөвсгөл Эрчим хүч ХХК-д тус ажлын машин механизм, ажиллах хүч, тээврийн зардал гэж 19.4 сая төгрөгийг ямар нэгэн гэрээ хэлцэлгүйгээр давхардуулан илүү олгосон.

Зориулалт бус зарцуулсан ТАХ-ний тухайд:

- ✓ Архангай аймаг 2.5 сая төгрөгийг, Баянхонгор аймаг 57.2 сая төгрөгийг, Баян-Өлгий аймаг 3.0 сая төгрөгийг, Говь-Алтай аймаг 7.5 сая төгрөгийг, Дорнод аймаг 92.6 сая төгрөгийг, Дундговь аймаг 81.8 сая төгрөгийг, Завхан аймаг 65.1 сая төгрөгийг, Өмнөговь аймаг 5.0 сая төгрөгийг, Сэлэнгэ аймаг 17.9 сая төгрөгийг, Төв аймаг 613.6 сая төгрөгийг, Ховд аймаг 6.1 сая төгрөгийг нийт 28 ажилд 952.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэлт: Аудитаар нийт 6,253.9 сая төгрөгийн зөрчилд 289.4 сая төгрөгийн 39 төлбөрийн акт, 5,406.6 сая төгрөгийн 49 албан шаардлага, 494.0 сая төгрөгийн 13 зөвлөмж хүргүүлсэн байна. Залилангийн шинжтэй, ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүй 63.9 сая төгрөгийн 3 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 97.8 хувь нь төлөвлөсөн зорилтот түвшний үр дүндээ хүрсэн байна

2.2.1 Улсын хэмжээнд бүрэн хэрэгжсэн 389,155.8 сая төгрөгийн 7,847 төсөл, арга хэмжээнээс 370,520.0 сая төгрөгийн 7,671 төсөл, арга хэмжээ буюу 97.8 хувь нь төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн бол 18,635.8 сая төгрөгийн 176 төсөл, арга хэмжээ буюу 2.2 хувь нь зорилтот түвшиндээ хүрээгүй байна.



Хүснэгт 8. Зорилтот түвшинд хүрсэн байдал

(сая төгрөг)

№	Аймаг, сумын нэр	Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Төсөл, арга хэмжээний зорилтод түвшний үр дүнд			
		тоо	гэрээний дүн	хүрсэн ТАХ		хүрээгүй ТАХ	
				тоо	дүн	тоо	дүн
1	2	3		5	6	7	8
1	Архангай	333	11,501.8	299	10,690.4	34	811.4
2	Баянхонгор	463	21,193.4	463	21,193.4		-
3	Баян-Өлгий	598	8,547.8	588	8,431.8	10	116.0
4	Булган	333	8,461.8	329	8,414.8	4	47.0
5	Говь-Алтай	400	11,390.5	398	11,261.4	2	129.1
6	Говьсүмбэр	67	3,442.4	65	3,426.3	2	16.0
7	Дархан-Уул	213	10,878.3	208	10,626.0	5	252.3
8	Дорноговь	218	46,655.8	218	46,655.8	0	-
9	Дорнод	396	23,740.4	337	16,432.8	59	7,307.6
10	Дундговь	296	11,505.6	296	11,505.6	0	-
11	Завхан	714	15,340.9	713	15,336.9	1	4.0
12	Орхон	261	12,073.0	261	12,073.0	0	-
13	Өвөрхангай	326	12,763.0	311	12,515.7	15	247.3
14	Өмнөговь	287	36,276.6	286	36,243.6	1	33.0
15	Сүхбаатар	280	21,694.6	274	21,471.8	6	222.8
16	Сэлэнгэ	251	17,858.6	251	17,858.6	0	-
17	Төв	395	25,611.3	395	25,611.3		-
18	Увс	408	9,166.6	408	9,166.6		-
19	Ховд	687	22,671.1	679	20,733.6	8	1,937.6
20	Хөвсгөл	506	13,984.8	499	13,626.2	7	358.6
21	Хэнтий	214	13,995.4	214	13,995.4		-
	Аймгийн дүн	7,646	358,753.7	7492	347,271.1	154	11,482.6
22	Нийслэл	201	30,402.1	179	23,248.9	22	7,153.2
	НИЙТ дүн	7,847	389,155.8	7,671	370,520.0	176	18,635.8

(Дэлгэрэнгүйг судалгаа 7-оос харна уу)

Хүснэгтээс харахад Архангай, Дорнод, Өвөрхангай аймаг, Нийслэл хамгийн өндөр буюу 15-59 ТАХ зорилтод түвшиндээ хүрээгүй бол Баянхонгор, Дорноговь, Дундговь, Орхон, Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий аймгуудын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-үүд зорилтод түвшиндээ бүрэн хүрсэн байна. Аудитын явцад иргэд олон нийтээс авсан **ОНХС-ийн 2023 оны хөрөнгөөр батлан хэрэгжүүлсэн бүтээн байгуулалтууд орон нутгийн хөгжлийг дэмжсэн үр дүнтэй ажил болсон уу?** гэсэн асуултад нийт иргэдийн 50 хувь нь **“Тийм”**, 6 хувь нь **“Үгүй”**, 44 хувь нь **“Сайн мэдэхгүй”** гэж хариулсан байна. Эндээс үзэхэд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд үр дүн үзүүлж байгаа ч зарим төсөл, арга хэмжээний тухайд зорилтот түвшинг бүрэн хангаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

Архангай аймаг:

- ✓ Эрдэнэбулган сумын 2022 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх 170.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Явган хүний зам тавих" ажлыг 2023.07.25-ны өдөр бүрэн дуусгаж, ашиглалтад хүлээлгэн өгөхөөр "Тайгер дизайн" ХХК-тай гэрээ байгуулсныг газар дээр нь очиж үзэхэд ажлын гүйцэтгэл дутуу, гэрээний хугацаа хэтэрсэн, гэрээний 10 дахь заалтын дагуу алданги тооцоогүй, гэрээний үүргийн биелэлтийг хангуулж ажиллаагүй,
- ✓ Өндөр-Улаан сум 45.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ЗДТГ-ын урд талбайг засах ажил, Хангай сумын 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Чандмана багийн барилга засварлах ажил, Тариат сум 51.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Эрчим хүчний 2 дэд станц шинээр байгуулах, хогийн цэгийн засварын ажлуудын гүйцэтгэгч нар нь гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй он дамжсан.
- ✓ Хашаат сумын 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлсэн хэрэгжүүлсэн 149.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Халуун усны барилга"-ын ажил болон Цагаан хад, Цайдам багуудад гаргасан 36.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худгийн цооногийн ажлуудад түрээслэгч иргэдтэй



төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн түрээсийн гэрээ байгуулаагүй, орлого төвлөрүүлээгүй.

- ✓ Батцэнгэл сумын 2023 оны ОНХС-ын хөрөнгөөр өмнөх оноос шилжин хэрэгжсэн 39.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Халуун усны барилга"-ын ажил ашиглагч иргэнтэй өмчийн ашиглалтыг сайжруулах, үр ашиг дээшлүүлэх чиглэлээр гэрээ байгуулаагүй.

Баян-Өлгий аймаг:

- ✓ Аймгийн төвийн суманд нийт 109.0 сая төгрөгийн өртөг бүхий гүний худаг гаргах ажлыг 8 ажлыг "Өлгий дриллинг" ХХК-тай шууд гэрээ байгуулж хэрэгжүүлснийг газар дээр нь шалгахад сумын төвд 1 гүний худаг, 6 дугаар багийн 1 гүний худаг ашиглалтад оруулаагүй
- ✓ Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 6.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй тоглоомын талбайн засварын ажил батлагдсан зураг төсөвгүй, чанаргүй хийгдсэн тул ажлын хэсэг хүлээн авалгүй дараа онд шилжүүлсэн.

Баянхонгор аймаг:

- ✓ Засаг даргын 2023 оны 03 сарын 10-ны өдрийн А/51 тоот захирамжаар Баянхонгор сумын нутаг дэвсгэрт 100 өрхийг хүлэмжийн аж ахуй эрхлэх ажлыг зохион байгуулж иргэнтэй байгуулсан гэрээнд иргэдийн тарьж ургуулсан ногоог хэрхэн борлуулах, өрхийн орлогын өсөлтийг яаж тооцох, иргэд хоорондоо хүлэмжээ дамлан худалдахгүй байх зэрэг асуудлыг тодорхой үнэлэх боломжтойгоор тусгаагүй.
- ✓ Оточ номгон өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг ашиглагч байгууллагаас "замын хайрга хөрс нь доош цөмөрсөн, ус зайлуулах суваг цооног байхгүй, борооны үеэр подвол руу ус ордог, ариун цэврийн өрөөний агааржуулалтын шугамаас бохирын үнэр тогтмол үнэртдэг, 11 дүгээр цэцэрлэгээс "барилгад хийгдсэн борооны ус зайлуулагчийн холбоосоор ус гоожиж, барилгын хана болон үүдний шат руу урсаж байгаагаас үүдний шатны пилтон ховхорсон", барилгын засварын явцад гарсан хог хаягдлыг цэцэрлэгийн хашаанд асгасныг цэвэрлээгүй" зэрэг гомдол ирсэн.
- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн Баянхонгор сумын 514 дүгээр байрны их засварын ажлыг шалгахад орцны будаг ховхорсон, засварын чанаргүй хийгдсэн.
- ✓ Баян-Овоо сумын Соёлын төвийн номын санд тохижилт хийх бараа материал нийлүүлэхээр "Асгамба сүмбэр" ХХК 2023.02.01-ний өдөр Баян-Овоо сумын Засаг даргатай 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаатай гэрээ байгуулж, 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр 8.6 сая, 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр 11.0 сая төгрөгийг тус аж ахуйн нэгжид шилжүүлсэн байхад ажлыг хийж гүйцэтгээгүй.
- ✓ Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Голден эко арт" ХХК-ийн гүйцэтгэж байгаа жишиг гудамж хорооллын 4 тал хашааны үнийг сумын ЗДТГ-аас 5.7 сая, 3 тал хашааны үнийг 4.2 сая төгрөгөөр тогтоосон, цаашид тус гудамжинд ямар журам баримтлах нь тодорхой бус, "Голден эко арт" ХХК-ийн гүйцэтгэж байгаа жишиг гудамжинд айлууд буусан хашааны үнэнд 14.4 сая төгрөгийг тушаасан, түүнийг төсөвт байгууллагуудын хашааны үнэнд зарцуулсан, Музейн тохижилтын тавилга нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт шалгарсан "Ерөөл нэмэх" ХХК нь орчин үеийн шаардлагад нийцсэн гадна талын 1 ширхэг камерыг суурилуулаагүй, 8 өрөө тус бүрд гэрэлтүүлгийг дутуу хийсэн, мөн үзэгчдийг хүлээн авах танхимыг тохижуулах ажлыг дутуу гүйцэтгэсэн, Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны засвар ажлыг гүйцэтгэгч "Могойн хөндий" ХХК нь гимнастикийн болон спорт авиралтын зориулалттай 2 ширхэг ханын шатыг хийж гүйцэтгээгүй, Цэвэр усны шугам тавих 98.6 сая төгрөгийн ажлыг "Могойн хөндий" ХХК гүйцэтгэхээр 2023.07.04-ний өдөр гэрээ байгуулсан бөгөөд аудитаар хийсэн ажлыг техникийн тодорхойлолттой тулган шалгахад иргэний танхимд эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөө, гар угаалтуурын хамт суурилуулж, ашиглалтад оруулах ажлыг хийж гүйцэтгээгүй.
- ✓ "Арслант хүлэг" ХХК 2023.02.01-ний өдөр Сумын нөөцөд хивэг, өвс бэлтгэн нийлүүлэх гэрээг байгуулж, 2023.04.01-ний өдрөөс өмнө 35.0 сая төгрөгийн 1000 боодол өвс, 1000 шуудай хивэг нийлүүлэх гэрээг байгуулж, 2023.02.09-ны өдөр 12.0 сая 2023.03.02-ны өдөр 12.0 сая төгрөгийг шилжүүлсэн байхад гэрээний үүргээ биелүүлээгүй байна. Тус ААН-тэй 2023.05.01-ний өдөр нэмэлт гэрээ байгуулж, 2023.05.31-ний өдөр 812 шуудай өвс, 684 боодол улаан хивэг нийлүүлэх 26.0 сая төгрөгийн гэрээ байгуулан, 2023.05.16-ны өдөр 26.0 сая төгрөгийг шилжүүлсэн байхад өвсийг хүлээлгэн өгөөгүй.

Булган аймаг:

- ✓ Хутаг-Өндөр сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн Наадмын талбайн байгууламж /цэнгэлдэх хүрээлэн/ шинээр барих 120.0 сая төгрөг, Уньт багийн соёлын төвийн их засвар 60.0 сая төгрөг,



Уньт, тээл, Хонгор багт мал тарилгын хашаа барих 33.0 сая төгрөг нийт 213.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэх хугацаа дууссан.

- ✓ Сэлэнгэ сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ЕБС-ийн шаардлагатай тоног төхөөрөмжийг 2023 оны 11 дүгээр сарын 03 өдрийн 11/012 тоот гэрээ байгуулж урьдчилгаа болох 4.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч одоог хүртэл тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй.
- ✓ Сумдын түвшинд үзэхэд татвар төвлөрүүлэх ажлыг хангалтгүй хэрэгжүүлснээс шалтгаалж татварын төлөвлөгөө тасардаг мөн ОНХС-ийн дансанд төвлөрүүлсэн татварын санхүүжилтийг бүрэн зарцуулахгүй байгаа нь татвар төлсөн малчид төрийн үйлчилгээг авч чадахгүйд хүрсэн.
- ✓ Хялганат тосгоны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 38.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Зорчигч тээврийн зогсоол барих, Худалдааны саравч барих 2 ажил нь гүйцэтгэх хугацаа дууссан боловч дутуу хийгдсэн, Ахмадын өргөөний барилгын зураг төсөв дууссан боловч хүлээж аваагүй.
- ✓ Орхон сумын ОНХС-гийн хөрөнгөөр сумын 24 өрхийн хашаа шинэчлэх "Гудамж төсөл" хэрэгжүүлэхээр төлөвлөж 10.0 сая төгрөгийн банз, материал худалдан авсан боловч хашаажуулах хийгдээгүй, Цэцэрлэгийн хүүхдийн тоглоомын талбайн ажлыг биетээр үзэхэд 1.5 сая төгрөгийн зөөлөвч резин дутуу хийгдсэн.

Говь-Алтай аймаг:

- ✓ "Хантайшир Уулын аймгийн 100 жил"-ийн ойн арга хэмжээний хүрээнд сумдын тохижилтын ажил, танилцуулга " төсөл арга хэмжээний самбар нийлүүлэх гэрээгээр 30 ширхэг самбар нийлүүлэгдэхээс 10 ширхэг самбар нийлүүлэгдээгүй. Сумууд 20 ширхэг самбарыг нягтлан бодох бүртгэлд орлого авсан боловч эзэмшигчид бодитоор байхгүй өөр суманд байршуулсан.
- ✓ Өмнөх онуудад аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 617.6 сая төгрөгийн 6 ажил, сумдын 819.3 сая төгрөгийн 12 ажлыг гэрээний хугацаанд хийж гүйцэтгээгүй, хэрэгжилт дутуу, үр дүн хангалтгүй

Дархан-Уул аймаг: 252.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-ний үр дүнг тооцож ажиллаагүй.

Дорноговь аймаг: аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 7,307.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 59 ТАХ нь зорилтод түвшний, үр дүндээ хүрээгүй.

Завхан аймаг: Алдархаан, Баянтэс, Баянхайрхан, Сонгино, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй сумдад инженерийн хийцтэй худаг гаргах 84.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр "Гранд инженеринг" ХХК шалгарсан ч санхүүжилт хүрэлцэхгүй гэх шалтгаанаар тус ажил хийгдэх боломжгүй болсон.

Өвөрхангай аймаг:

- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Баянгол сумын ЕБС-ийн дээврийн засвар, Гучин-Ус сумын ЕБС-ийн дотуур байрны засвар, Баян-Өндөр сумын ЕБС-ийн дотуур байрны засвар, Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 2-р сургуулийн гадна засварын гүйцэтгэлийг чанар муутай хийсэн.
- ✓ Баруунбаян-Улаан сумын эмнэлэг, ЕБС-д суурилуулсан ус цэвэршүүлэгч нь эвдэрч ашиглалтгүй болсон.
- ✓ Баянгол сумын ЕБС-ийн гал тогооны хоол үйлдвэрлэлийн өрөөг засварласан боловч тухайн ууршилтаас болж нурсан байдалтай, ЕБС-ийн дотуур байрны халуун ус, угаалга, хатаалгын өрөөг тохижуулах засвар хийсэн боловч чанаргүй болсон.
- ✓ Гучин-Ус сумын гэр хорооллыг дулааны шугам сүлжээнд холбох ажил 296.2 сая төгрөгөөр хийгдсэн боловч тухайн ажил ашиглалтгүй.
- ✓ Хайрхандулаан сумын ЕБС-ийн стандартад нийцсэн хүнсний агуулахтай болохын тулд хуучин агуулахыг засварлах ажил 53.5 сая төгрөгөөр хийгдсэн боловч ашиглалтгүй, мөн нийтийн эзэмшлийн талбайд лед дэлгэц хийх 35.0 сая төгрөгийн ажил дуусаагүй, ашиглалтад ороогүй.
- ✓ Хужирт сумын Төрийн албан хаагчийн орон сууц шинээр баригдаж байгаа 674.0 сая төгрөгийн ажил дуусаагүй, зогсонги байдалтай, 2-р цэцэрлэгийн хүнсний агуулах барих ажил 19.6 сая төгрөгөөр хийгдсэн боловч чанар муу болсон, дахин засах шаардлагатай, нийтийн бие засах газар 12.4 сая төгрөгөөр хийгдсэн ч ашиглалтгүй, 4-р цэцэрлэг нь 2 бүлэгтэй 50 хүүхэдтэй боловч 2 тасалгаатай хүнсний агуулах 15.0 сая төгрөгөөр барьсан нь огт хэрэгцээ шаардлагагүй, ашиглалтгүй.

Өмнөговь аймаг: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн "Сургуулийн анги танхим тохижуулах мэдээлэл зүйн кабени" тохижуулахад 20 ширхэг компьютер нийлүүлсэн боловч үзүүлэлт нь ажлын даалгавраас зөрүүтэй.

Сүхбаатар аймаг: Нийт 222.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ нь гэрээт хугацаандаа дуусаагүйгээс өгөөж хүртэх хугацаа хойшилж, үр ашиг буурсан.



Ховд аймаг: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх” ажил, Жаргалант сумын “Нийтийн тээврийн үйлчилгээнд автобус худалдан авах”, “Өрхийн эрүүл мэндийн төв”-ийн барилгын ажил, ухаалаг худаг шинээр гаргах, бичил үйлчилгээний төвийн барилгын ажил, Мөст сумын ЗДТГ-ын засварын ажил зэрэг нь гэрээ дүгнээгүй, хугацаандаа хүлээлгэн өгөөгүй, чанаргүй хийгдсэн.

Хөвсгөл аймаг: Галт сум 4 цэгт шинээр гаргасан худгийн зураг төсөвт тусгагдсан худаг дотор байршуулах 1.5 метр куб хэмжээтэй цэвэр усны нөөц “нерж” савны оронд 1м3 багтаамжтай хуванцар савыг худаг тус бүрд байршуулсан байхад хүлээн авсан, Мөрөн сум Ухаалаг худгийн тохижилтын ажлын зураг төсөвт заасан Долоогоно 3 ширхэг, Агч мод 3 ширхэг, Нарс мод 6 ширхэг суулгаагүй, мөн 9,11,12-р баг хөгжлийн төвийн урд байрлах хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажлын даалгаварт заасан, талбайн тэмдэг тэмдэглэгээг хийгээгүй, талбайн хажууд 2 ширхэг хогийн сав байршуулаагүй байхад захиалагч ашиглалтад хүлээн авсан зэрэг нийт 18,635.8 сая төгрөгийн 176 ТАХ-ний гүйцэтгэл дутуу, чанаргүй, гэрээний хугацаанд ажлаа хийгээгүй он дамжсан зэрэг шалтгаанаар тайлант онд төлөвлөсөн зорилтод түвшиндээ хүрээгүй байна.

Шийдвэрлэлт: Дээрх нийт 7,560.1 сая төгрөгийн зөрчилд 89.4 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, зөрчлийг давтан гаргахгүй байх 3,803.4 сая төгрөгийн 44 албан шаардлага, 3,667.2 сая төгрөгийн 29 зөвлөмжийг хүргүүлсэн байна.


2.2.2. Улсын хэмжээнд 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр 8,672 төсөл, арга хэмжээнд 408,507.7 сая төгрөгийг зарцуулснаас 45.4 хувь буюу 185,597.3 сая төгрөг нь үндсэн хөрөнгө, 17.3 хувь буюу 70,762.1 сая төгрөг нь барилга байгууламж, 4.5 хувь буюу 18,265.6 сая төгрөг нь их засварт, 2.7 хувь буюу 11,076.1 сая төгрөг нь тоног төхөөрөмжид зарцуулагдсан байна. Харин 30.1 хувь буюу 122,806.5 сая төгрөгийг урсгал зардлын шинжтэй ТАХ-нд зарцуулжээ.

Хүснэгт 9. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний ангилал

(сая төгрөг)

Аймгийн нэр	Нийт гүйцэтгэл	Үүнээс:									
		Барилга байгууламж		Тоног төхөөрөмж		Их засвар		Бусад үндсэн хөрөнгө		Урсгал зардал	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Архангай	12,226.3	1,704.4	13.9%	256.7	2.1%	11.8	0.1%	10,253.4	83.9%	-	-
Баянхонгор	20,940.8	20,940.8	100%	-	-	-	-	-	-	-	-
Баян-Өлгий	8,687.4	3,425.9	39.4%	1,447.4	16.7%	842.9	9.7%	2,971.2	34.2%	-	-
Булган	10,943.5	-	-	-	-	-	-	10,943.5	100%	-	-
Говь-Алтай	16,388.3	-	-	-	-	-	-	16,260.5	99.2%	127.8	0.8%
Говьсүмбэр	4,243.0	-	-	-	-	-	-	3,568.4	84.1%	674.6	15.9%
Дархан-Уул	13,217.8	-	-	-	-	-	-	12,985.1	98.2%	232.7	1.8%
Дорноговь	34,567.8	-	-	-	-	-	-	-	-	34,567.8	100%
Дорнод	25,545.5	-	-	-	-	-	-	25,545.5	100%	-	-
Дундговь	12,788.4	-	-	-	-	-	-	12,788.4	100%	-	-
Завхан	16,475.7	-	-	-	-	-	-	16,475.7	100%	-	-
Орхон	15,408.3	12,948.6	84.0%	1,423.9	9.2%	732.2	4.8%	298.6	1.9%	5.0	0.03%
Өвөрхангай	14,419.1	-	-	-	-	-	-	14,419.1	100%	-	-
Өмнөговь	34,014.4	-	-	-	-	-	-	-	-	34,014.4	100%
Сүхбаатар	17,245.7	3,271.2	19.0%	1,489.7	8.6%	1,193.9	6.9%	11,290.9	65.5%	-	-
Сэлэнгэ	22,112.6	12,760.8	57.7%	2,538.5	11.5%	3,232.1	14.6%	3,581.2	16.2%	-	-
Төв	25,806.8	4,886.5	18.9%	1,235.4	4.8%	5,407.0	21.0%	14,277.9	55.3%	-	-
Увс	10,370.6	-	-	-	-	-	-	10,370.6	-	-	-
Ховд	26,029.6	10,823.9	41.6%	2,684.5	10.3%	6,840.9	26.3%	5,680.3	21.8%	-	-
Хөвсгөл	15,108.3	-	-	-	-	-	-	-	-	15,108.3	100%
Хэнтий	13,770.8	-	-	-	-	-	-	13,759.3	99.9%	11.5	0.1%
Нийслэл	38,196.9	-	-	-	-	4.8	0.01%	127.7	0.3%	38,064.4	99.7%
нийт дүн	408,507.7	70,762.1	-	11,076.1	-	18,265.6	-	185,597.3	-	122,806.5	-
Хувь	100%	17.3%		2.7%		4.5%		45.4%		30.1%	

(Эх сурвалж: Сангийн яам Э-тайлан системээс)



ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт ТАХ-г хэмжээг чиг үүргээр нь авч үзвэл: “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, шинжлэн ухаан, цахим технологи”-д 1951 ТАХ буюу 22.5 хувь нь, “Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ”-нд 1754 ТАХ буюу 20.2 хувь нь, “Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалахад” 2089 ТАХ буюу 24.1 хувь нь, “Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулахад” 471 ТАХ буюу 5.4 хувь нь,

“Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулахад” 394 ТАХ буюу 4.5 хувь нь, “Ажлын байр бий болгоход” 149 ТАХ буюу 1.7 хувь нь, “Байгаль орчныг хамгаалахад” 134 ТАХ буюу 1.5 хувь нь зарцуулагдсан байна. Харин 1602 ТАХ буюу 18.5 хувь нь малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөдөө аж ахуйн салбарт зарцуулсан байна. Дээрх байдлаас харахад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ТАХ-үүд орон нутгийн хөгжилд тодорхой үр дүнгээ өгч байна.

Төлөвлөсөн зорилтод түвшиндээ хүрсэн, орон нутгийн хөгжилд хувь нэмэр өгөхүйц үр нөлөөтэй ажил болсон зарим [сайн жишээнээс](#) дурдвал:

Архангай:

- ✓ Хайрхан сум нь 2023 онд 29.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шүдний кабинет тохижуулалт”-ын ажлыг хэрэгжүүлснээр иргэдийн эрүүл мэндийг хамгаалсан, үр дүнтэй ажил болсон төдийгүй сумандаа шүдний эмчилгээ, үйлчилгээг ЭМДС-ийн хөнгөлөлтөөр хамрагдах боломжтой болсон байна.
- ✓ Өгийнуур сум нь 2023 онд 196.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын төвийн нутаг дэвсгэрт 540м урттай нэгдсэн халаалтын болон цэвэр усны дэд бүтэц”-ийн ажлыг гүйцэтгэснээр 25 айл өрх шугамын өргөтгөлд холбогдож байгаа цаашлаад 60 гаруй өрх холбогдохоор байгаа нь ард иргэд ая тухтай амьдрах нөхцөл бүрдсэн.
- ✓ Төвшрүүлэх сум нь 2023 онд 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн 2 худгийг ухаалаг системд холбох, тоног төхөөрөмж суурилуулах” ажлыг хэрэгжүүлснээр сумын төвийн 1200 иргэд 24 цагийн ундны усаар хангагдаж, сумын төсөвт 2024 оны 6 сарын байдлаар 6.6 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Баянхонгор:

- ✓ Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар цахилгааны эх үүсвэрийн чадлыг 6кВт-аас 10кВт-т шилжүүлэхэд шаардлагатай 26 трансформаторыг байршуулах ажил хийгдэж байгаа бөгөөд тус ажлын үр дүнд аймагт амьдарч байгаа иргэдийн цахилгааны баталгаат эх үүсвэрийг хангах;
- ✓ Баянхонгор сум “Хог хаягдлыг бууруулах Эко кэйш машиныг худалдан авах” төсөл, арга хэмжээнд 20.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд Баянхонгор сумд байрлуулж хог хаягдлыг худалдан авах боломжтой болсон, мөн “Зөөврийн усан сангуудыг ухаалаг болгох” төсөл, арга хэмжээнд 160.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд гэр хорооллын иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, цаг хугацааг хэмнэсэн, орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн байна.
- ✓ Галуут сум “Стандартын шаардлага хангасан халуун ус, нийтийн 00 барих” төсөл, арга хэмжээнд 147.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд сумын ард иргэд эрүүл ахуйн шаардлагад нийцсэн орчинд үйлчлүүлэх боломж бүрдэхийн зэрэгцээ ажлын байрыг бий болгосон.
- ✓ Заг сумын ОНХС-ийн хөрөнгөөр 19.8 сая төгрөгөөр Соёлын төвд байгаль, амьтны музейтэй болох ажлыг хийж гүйцэтгэснээр иргэд, хүүхэд багачуудын соёлын мэдлэг дээшилж, орлого нэмэгдэх боломжтой болсон;



- ✓ Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгийн 10.0 сая төгрөгөөр халуун усны барилгын засварласнаар ажлын байр нэмэгдсэн, “Эрэн хайх аврах салбарын авто машины гараж”-ийн ажилд 20.0 сая төгрөгийг баталж, албан хаагчдын оролцоотойгоор 2 автомашины гараж барьсан.
- ✓ Хүрээмарал сумын ОНХС-ийн хөрөнгөөр Энергийн төвийг түшиглэж аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээнд 59.0 сая төгрөгөөр жуулчны баазыг барьснаар цаашид аялал жуулчлал хөгжиж, орон нутгийн орлого нэмэгдэх боломж бүрдсэн.
- ✓ Баянцагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн “4, 5 дугаар багийн төв барих” төсөл, арга хэмжээнд 300.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд багийн төв болон ахмадын өргөөг нэг дор шийдсэн, ариун цэврийн байгууламж, дэд бүтэц нь орчин үеийн стандартад нийцсэн нь сумд хэрэгжсэн сайн жишээ болсон байна.

Ховд:

- ✓ Чандмань сумын ОНХС-ийн хөрөнгөөр Соёлын төвийн номын сангийн уншлагын танхим тохижуулах тавилга, эд хогшил нийлүүлснээр номыг стандартын дагуу хадгалах, үйлчлэгчийн ном унших таатай орчин бүрдсэн,
- ✓ Мөст суманд нийлүүлсэн ковш-50 маркийн трактор, сумын төвийн айл өрхүүдийг үер усны аюулаас хамгаалах боломж бүрдсэн,
- ✓ Алтай сумын ЭМТ-д ЭХО аппарат, Эрдэнэбүрэн сум Цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппаратыг авснаар сумын иргэд үзлэг оношилгоо, шинжилгээг сум орон нутагтаа хийх боломж бүрдсэн,
- ✓ Үенч сум айл өрхүүдийн цахилгааны хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор трансформатор нэмж суурилуулснаар иргэдийн амьдрах таатай орчин бүрдүүлсэн,
- ✓ Булган сумын 14 төсөвт байгууллагуудыг 20 гаруй барилга байгууламжийг цэвэр, бохир усны инженерийн шугамын холболтыг 621.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн нь албан хаагчдын ажиллах ард иргэдийн үйлчлэх таатай орчин, хүүхдийн сурч боловсрох таатай орчин сайжирсан, нарийн мэргэжлийн эмчийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор “Орон сууц”-аар хангах зорилгоор 2 өрөө байр худалдан авсан,
- ✓ Дарви сумын ЭМТ-д авто машин нийлүүлснээр ойрын дуудлага, аймагт өвчтөн хүргэхэд цаг хугацаа, шатахуун хэмнэсэн нь үр өгөөж бий болсон.
- ✓ Мөнххайрхан сумын төвийн айл өрх, албан газруудыг хог хаягдлыг зайлуулахад “Хогны машин” авснаар сумын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх үр дүнтэй ажил болсон байна.
- ✓ Манхан сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлэг, сумын түүхт 100 жилийг угтан Соёлын төвийн урлагийн хувцас шинэчлэх зэрэг ажлууд үр дүнтэй хийгдэж сум болон байгууллагын өнгө үзэмжийг нэмсэн,
- ✓ Жаргалант сумын ОНХС-аар хийгдсэн Их монгол хорооллын гадна болон дотор тохижилт, авто зогсоол, хүүхдийн тоглоомын талбай,
- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Шинэ суурьшлын бүсийн айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангаж иргэдийн ая тухтай орчныг бүрдүүлсэн, Жаргалант сумын Цамбагарав, Магсаржав багийн иргэд, хөдөлмөрчдийг зуны улиралд хэрэглээний халуун усаар хангасан нь иргэдийн сэтгэлд нийцсэн арга хэмжээ болсон, Шинэ суурьшлын бүсэд баригдаж байгаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэсэн нь иргэдийн ая тухтай орчныг хангасан, 30 айлын гаднах тоглоомын талбайн ажил нь хүүхдүүд тоглож наадах таатай орчныг бүрдүүлсэн байна.

Говь-Алтай:

- ✓ Есөнбулаг сумын нутаг дэвсгэрийн теле хяналтын систем шинэчлэх, шинээр суурилуулах арга хэмжээ” төсөл арга хэмжээний хүрээнд дуу дүрсний өндөр нарийвчлалтай иж бүрэн 150 камерыг суурилуулсан, Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар”-ын усан бассейны барилгын агааржуулалт, халаалтын системийг сайжруулснаар орон нутгийн иргэд аюулгүй, амар тайван, ая тухтай орчинд амьдрах, үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Увс:

- ✓ Бөхмөрөн сумын нийтийн халуун усны байрыг нэгдсэн халаалтын шугамд холбосноор иргэд тав тухтай дулаан орчин үйлчилгээ авах боломж бүрдсэн.



- ✓ Завхан сумын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг шүд эрүүлжүүлэх хөтөлбөрт хамруулсан нь эцэг, эх, иргэдээс талархал хүлээсэн.
- ✓ Наранбулаг сумын Гэр хорооллын 04 кВт.ц цахилгаан дамжуулах шугамын шинэчлэл, гэрэлтүүлгийн ажил хийгдсэнээр иргэдийн амьдрах орчин сайжирсан.
- ✓ Өмнөговь сумын сургуулийн дотуур байрны ногооны зоорийг шинэчилсэн нь хүүхдийн хоолны материалын хадгалалт хамгаалалт сайжирсан.
- ✓ Сагил сумын хилийн заставуудын хамгаалалтын тор, хяналтын камер тоног төхөөрөмжийг шинэчилснээр малын хулгайн гэмт хэрэг багасах боломж бүрдсэн.
- ✓ Тэс сумын төв зам дагуу ногоон байгууламж хайсан хашаа усалтын систем хийснээр сумын өнгө үзэмж нэмэгдэж, ая тухтай орчин бүрдсэн.
- ✓ Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвд шаардлага хангасан чанартай шүдний тоног төхөөрөмж нийлүүлснээр иргэд цаг алдалгүй үйлчилгээ авах нөхцөл бүрдсэн, мөн 2 багт худгийг жишиг худаг болгож засварласан нь иргэдийн ундны усны чанар хүртээмж дээшилсэн.
- ✓ Улаангом сумын нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй барьсан авто гараашнуудыг буулгах ажил хийгдсэнээр орчны тохижилт сайжирсан, ухаалаг худгуудад ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулснаар 3000 гаруй айл өрх эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усаар хангагдах боломж бүрдсэн байна.

Өмнөговь:

- ✓ Баяндалай сум Шүдний кабинет байгуулах, шүдний тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд суурин болон явуулын үзлэг эмчилгээ хийх боломжтой болсон байна. Сумын 144 иргэн шүдний нарийн мэргэжлийн эмчилгээ авч, 97 хүүхэд үзлэг оношилгоонд хамрагдсан байна.
- ✓ Сэврэй сум гэрэлтүүлэг, камержуулалт нэмэгдүүлэх ажлын хүрээнд: Нийлүүлэгдсэн камер нь дүрслэл сайн холдуулж, ойртуулдаг орчноо бүтэн эргэж хянадаг байна. Мөн гэрэлтүүлэг цахилгаан зарцуулалт бага байна.
- ✓ Аймгийн ОНХС-ын хөрөнгөөр Номгон, Цогт-Овоо, Сэврэй сумыг дулааны найдвартай эх үүсвэрээр хангах ажлын хүрээн уурын зуух шинээр барих, Номгон, Баяндалай, Цогт-Овоо, Ноён, Сэврэй сумын төвийн дулаан, цэвэр, бохирын шугам сүлжээг шинээр барих, Манлай сумын төвийн гэр хорооллын ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөх зэрэг ажлууд нь ард иргэдээс сайн үнэлгээ авсан.

АНТАГ-аас ирүүлсэн судалгаа, тайлангаас үзэхэд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь төлөвлөсөн зорилтод түвшиндээ хүрсэн сайн талтай ч зарим аймгуудад орон нутгийн хөгжилд үр нөлөөгүй, урсгал шинжтэй арга хэмжээнд хөрөнгийг зарцуулсан зөрчил гарсаар байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- ✓ Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Орон нутгийн барилгын их засварын ажлыг 1,549.4 сая төгрөгөөр гүйцэтгэхээр "Буянт хөрс наран" ХХК-тай 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулж, тус төсөл арга хэмжээнд 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөс 300.0 сая төгрөгийг баталж, шилжүүлсэн байхад хашаа барьснаас өөр ажил хийгээгүй, тус ажлыг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр ашиглалтад өгөхөөр гэрээнд заасан боловч 2024 онд үлдэгдэл санхүүжилт бүрэн батлагдаагүй байгаа нь төсвийн үр ашиг саарах, төсөвт өртөг нэмэгдэх, төсөл арга хэмжээ чанаргүй хийгдэх эрсдэлтэй байна.
- ✓ Говь-Алтай аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс урамшуулал, дэмжлэг, тусламж хэлбэрээр 11 төсөл арга хэмжээнд 2,883.3 сая төгрөг зарцуулсан.
- ✓ Дорнод аймгийн Халхгол сумын ОНХС-гийн хөрөнгөөс 20.0 сая төгрөгийг байгаль орчны "Зөвлөх үйлчилгээ" нь гэрээний үүргийн хэрэгжилт нь хангалтгүй, тайланг хэрхэн үнэлсэн нь тодорхойгүй.
- ✓ Завхан аймаг ОНХС-ийн 964.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 ТАХ-г хэт жижиглэсэн 5.0-20 хүртэл сая төгрөгийн төсөвт өртөг бүхий, тухайн байгууллагын төсөвт тусган хэрэгжүүлэх боломжтой урсгал болон хөрөнгийн зардалд төлөвлөж, зарцуулсан.
- ✓ Өвөрхангай аймаг Арвайхээр сумын 9-р багийн тоглоомын талбайн тохижилтын 46.5 сая төгрөгийн ажил дуусаагүй, моджуулах ажил хийгдээгүй, Арвайхээр сумын Гэр хорооллын,



нийтийн эзэмшлийн талбайн камерын тоог нэмэгдүүлэх 59.3 сая төгрөгийн ажил хүлээж аваагүй, Арвайхээр сумын нийтийн бие засах газар 47.8 сая төгрөгөөр баригдсан боловч сууж ажиллуулах хүн олдохгүй одоогоор ашиглалтгүй, Арвайхээр сумын 8, 12 дугаар багт 2022 онд 98.5 сая төгрөгөөр он дамжиж хийгдсэн хүүхдийн тоглоомын талбайн зарим нь эвдэрсэн, Арвайхээр сумын 6 дугаар багт 2023 онд 46.5 сая төгрөгөөр хийгдсэн хүүхдийн тоглоомын талбайн зарим хийсэн ажил нь хулгайд алдагдсан, мод суулгалтын ажил хийгдээгүй.

Шийдвэрлэлт: Дээрх нийт 4,446.6 сая төгрөгийн зөрчилд 3,481.8 сая төгрөгийн 13 албан шаардлага, 964.7 сая төгрөгийн 26 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Харин 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлжээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүд орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж байгаа ч аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд ТАХ-ний үр дүн, үр өгөөжийг урьдчилан тооцохгүйгээр төсвийн байгууллагын урсгал зардлын шинжтэй, богино хугацааны хэрэгцээ шаардлагыг хангасан төсөл арга хэмжээнд төлөвлөн зарцуулж байгаа нь сангийн хөрөнгийн үр дүн, үр өгөөжийг бууруулж, төлөвлөсөн зорилтод түвшиндээ хүрэхгүй байх эрсдэлийг бий болгож байна.

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон зарим хөрөнгө ашиглалтгүй байна

2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн 95.2 хувь буюу 366,584.6 сая төгрөгийн 7,472 төсөл арга хэмжээг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байгаа бол 2.6 хувь буюу 22,463.8 сая төгрөгийн 201 төсөл арга хэмжээний хөрөнгө ашиглалтгүй байна.

Хүснэгт 10. Хөрөнгийн ашиглалтын байдал

(сая төгрөгөөр)


Аймаг, сумын нэр	Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт					
	тоо	гэрээний дүн	Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж буй ТАХ		Зориулалтын бус ашиглаж буй ТАХ		Огт ашиглаагүй ТАХ	
			тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Архангай	333	11,501.8	330	11,131.0	0	-	3	370.8
Баянхонгор	463	21,193.4	457	20,919.5		-	6	273.8
Баян-Өлгий	598	8,547.8	589	8,441.8	1	2.5	8	103.5
Булган	333	8,461.8	330	8,427.8		-	3	34.0
Говь-Алтай	400	11,390.5	397	11,355.6		-	3	34.9
Говьсүмбэр	67	3,442.4	36	3,262.2	2	54.8	5	125.4
Дархан-Уул	213	10,878.3	211	10,515.2		-	2	363.1
Дорноговь	218	46,655.8	191	46,414.7	0	-	27	241.1
Дорнод	396	23,740.4	324	13,784.4		-	72	9,956.0
Дундговь	296	11,505.6	290	11,345.7		-	6	159.9
Завхан	714	15,340.9	669	15,260.8	1	4.0	4	76.1
Орхон	261	12,073.0	261	12,073.0	0	-	0	-
Өвөрхангай	326	12,763.0	316	12,254.7	0	-	10	508.3
Өмнөговь	287	36,276.6	280	35,276.7	-	-	7	1,000.0
Сүхбаатар	280	21,694.6	178	21,694.6	-	-	-	-
Сэлэнгэ	251	17,858.6	251	17,858.6	0	-	0	-
Төв	395	25,611.3	395	25,611.3		-		-
Увс	408	9,166.6	408	9,166.6		-		-
Ховд	687	22,671.1	679	21,173.6	4	46.2	4	1,451.3
Хөвсгөл	506	13,984.8	496	13,604.6		-	10	380.3
Хэнтий	214	13,995.4	208	13,824.9		-	6	170.5
Аймгийн дүн	7,646	358,753.7	7,296	343,397.4	8	107.5	176	15,248.9
Нийслэл	201	30,402.1	176	23,187.2			25	7,214.9
Нийт дүн	7,847	389,155.8	7,472	366,584.6	8	107.5	201	22,463.8

(Судалгаа 7)



Харин бүрэн хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээний 2.6 хувь буюу 22,463.8 сая төгрөгийн үнийн дүн бүхий 201 төсөл арга хэмжээний хөрөнгө ашиглалтын явцад эвдэрч, гэмтсэн, мэргэжлийн боловсон хүчингүй, зориулалтын байргүй, хариуцагч тодорхойгүй, чанаргүй хийгдсэнтэй холбоотой ашиглалтгүй байна.

Дүрслэл 10. Ашиглагч байгууллагын чанарын үнэлгээ



ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний байдлыг ашиглагч байгууллагаас 83.3 хувь нь ашиглалт “Сайн”, 15.1 хувь нь ашиглалт “Дунд”, 1.6 хувь нь ашиглалт “Муу” гэж үнэлсэн байна. Харин иргэд олон нийтээс авсан “Танай орон нутагт орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр бий болсон бүтээн байгуулалт, хөрөнгийн ашиглалтад та ямар үнэлгээ өгөх вэ?” гэсэн асуулгад нийт иргэдийн 32 хувь нь “Сайн”, 47 хувь нь “Дунд”, 8 хувь нь “Хангалтгүй”, 13 хувь нь “Мэдэхгүй” гэж

хариулсан байна. Мөн “Та ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлын чанар, гүйцэтгэлд ямар үнэлгээ өгөх вэ?” гэсэн асуулгад иргэдийн 31 хувь нь “Сайн”, 46 хувь нь “Дунд”, 9 хувь нь “Хангалтгүй”, 14 хувь нь “Мэдэхгүй” гэж хариулсан байна.

Аудитаар ашиглалтгүй хөрөнгөтэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай 370.8 сая төгрөгийн 3 хөрөнгө, Баянхонгор 273.8 сая төгрөгийн 6 хөрөнгө, Баян-Өлгий 103.5 сая төгрөгийн 8 хөрөнгө, Булган 34.0 сая төгрөгийн 3 хөрөнгө, Говь-Алтай 34.9 сая төгрөгийн 3 хөрөнгө, Говьсүмбэр 125.4 сая төгрөгийн 5 хөрөнгө, Дархан-Уул 363.1 сая төгрөгийн 2 хөрөнгө, Дорноговь 241.1 сая төгрөгийн 27 хөрөнгө, Дорнод 9,956.0 сая төгрөгийн 72 хөрөнгө, Дундговь 159.8 сая төгрөгийн 6 хөрөнгө, Завхан 76.1 сая төгрөгийн 4 хөрөнгө, Өвөрхангай 508.3 сая төгрөгийн 10 хөрөнгө, Өмнөговь 999.9 сая төгрөгийн 7 хөрөнгө, Ховд 1,451.3 сая төгрөгийн 4 хөрөнгө, Хөвсгөл 380.2 сая төгрөгийн 10 хөрөнгө, Нийслэл 7,214.8 сая төгрөгийн 25 хөрөнгө ашиглалтгүй байна.

Шийдвэрлэлт: Дээрх нийт 3,460.8 сая төгрөгийн зөрчилд 4.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчил арилгуулах 1,500.7 сая төгрөгийн 11 албан шаардлага, 1,956.1 сая төгрөгийн 17 зөвлөмж хүргүүлсэн байна. Ашиг сонирхлын зөрчил байж болзошгүй 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Дээрх байдлаас харахад захиалагч талаас төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлага, хүртэх үр өгөөж, холбогдох тооцоо судалгааг бодитой тооцоогүй, гүйцэтгэгч нар ажил, үйлчилгээг чанаргүй гүйцэтгэснээс зарим аймагт ашиглалтгүй хөрөнгүүд бий болж, тухайн орон нутагт ажлын байр нэмэгдэх, эрүүл, аюулгүй амьдрах орчин бүрдэх, иргэдийн орлого нэмэгдэх боломжийг алдсан байна.

2.3.2. “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалтад “ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна” гэж заасан. Гэтэл хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүйгээс хөрөнгө эзэнгүйдэж эвдэрч, гэмтэх, алдагдах, дутагдах, бусдад ашиглуулах нөхцөл бүрдсэн байна. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон 2,018.9 сая төгрөгийн хөрөнгө хадгалалт, хамгаалалтгүй байна. *Тухайлбал:*



Хүснэгт №11. Хадгалалт, хамгаалалт алдагдсан ТАХ

(сая төгрөг)

№	Аймгийн нэр	Төсөл, арга хэмжээний нэр	ТАХ-ний тоо	Төсөв /сая.төг/	Тайлбар
1	Баянхонгор	Хуучин хогийн цэгийн 1 га талбай биологийн нөхөн сэргээлт хийж, мод тарих, Тэрбум мод үндэсний хөтөлбөр,	3	39.9	Арчлалт хамгаалалт хангалтгүй
2	Булган	Хутаг-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр өвсний нөөцийг бүрдүүлэх ажил	1	0.3	Дутагдсан
3	Говьсүмбэр	Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгт дээжийн хөргөгч, Сүмбэр сумын ИТХ-ын ухаалаг дэлгэц, 2 дугаар сургуулийн шүүгчийн онооны самбар зэрэг худалдан авах	3	13.4	Хадгалалт хамгаалалт зохисгүйгээс ашиглалтгүй
4	Дархан-Уул	Хонгор сумын 11 дүгээр сургууль, Дархан суманд "Гоё цэцэрлэг" төслийн хүрээн тоног төхөөрөмж нийлүүлэх, Шарын гол сумын хэмжээнд 4 тоглоомын талбай, сүүдрэвч хийх, Авто замын нягтаршуулагч	4	44.4	Хөрөнгө бодитоор оршин байхгүй бусдад ашиглуулсан, эвдэрсэн
5	Дорнод	Хэрлэн сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 255.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ	2	255.4	Хадгалалт, хамгаалалтгүй
6	Дундговь	Зүүн 4 замын гэрэл дохиог засварлах, 3,5 км улсын чанартай авто замын гэрэлтүүлэг хийх, Жишиг хүүхдийн тоглоом, амралт чөлөөт цаг өнгөрөөх талбай, Аймгийн төвийн нийтийн халуун усны их засвар, Наадмын талбайд сүүдрэвч сандлын тоог нэмэгдүүлэх, шинэчлэх	5	1292.3	Эвдэрч, гэмтсэн
7	Завхан	Төв зам дагуу нутгийн брэнд бүтээгдэхүүний борлуулалтын 3 цэг байгуулах	1	25.0	Эвдэрч, гэмтсэн
8	Өмнөговь	Баруун, Зүүн байрны тоглоомын талбайг тохижуулах, Гэр бүл хөгжлийн төв"-ийн их засвар	2	143.1	Эвдэрч, гэмтсэн
9	Ховд	Мах, сүү, ногоо, жимс борлуулах цэг, Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, Хүүхдийн тоглоомын талбай, Усан оргилуур бүхий цэцэрлэгт хүрээлэн, Шуудан холбооны салбар барилга, Нийтийн номын сангийн дэргэдэх тохижилтын ажил	6	205.1	Ашиглалт, хадгалалт хамгаалалтгүй
Нийт дүн			27	2,018.9	

Шийдвэрлэлт: Дээрх нийт 201.8 сая төгрөгийн зөрчилд 3.6 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, зөрчил арилгуулах 106.2 сая төгрөгийн 10 албан шаардлага, 92.0 сая төгрөгийн 7 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Дээрх байдлаас харахад ялангуяа нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцаж байгаа байгууллагын хяналт сулаас хөрөнгө эзэнгүйдэж, эвдэрч гэмтэн ашиглалтгүй болдог. Мөн хөрөнгийн чанар, гүйцэтгэл, хадгалалт, хамгаалалт муу байгаа нь хөрөнгийг дахин засаж сэлбэх, урсгал засвар хийх шаардлага үүсэж, төсвийн зардлыг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгож байна.

БҮЛЭГ 3. ОНХС-ИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ БОЛОН УДИРДЛАГА МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД ИЛ ТОД, ҮНЭН ЗӨВ МЭДЭЭЛЭХ БАЙДАЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА


3.1. ОНХС-ийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна

3.1.1. Нийт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 47.3 хувьд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, 70.5 хувьд дотоод аудитын нэгжээс хяналт хэрэгжүүлээгүй байна



"Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.2.2³², 9.4³³, 9.5³⁴-т ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон тус журмын хэрэгжилтэд аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх хороо, иргэний нийгмийн байгууллагууд, дотоод болон хөндлөнгийн аудитын байгууллага нь хяналт тавьж ажиллахаар заасан. Дүрслэл 11. ОНХС-ийн хяналт

Тус журмын хүрээнд 2023 онд гүйцэтгэсэн 8,672 төсөл хэмжээнд хяналт хэрэгжүүлсэн эсэхийг АНТАГ-уудаас ирүүлсэн тайлан, судалгааг авч нэгтгэн авч үзэхэд шат, шатны ИТХ-аас 4,567, дотоод аудитын нэгжээс 2,554 төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлжээ. Өөрөөр хэлбэл: ИТХ-аас нийт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 52.7 хувьд, дотоод аудитын нэгжээс 29.5 хувьд хяналт хийжээ. Аймаг, нийслэл, сум, дүүргээр авч үзвэл:



Хүснэгт 12. ОНХС-ийн хяналт аймаг, нийслэлээр

№	Аймаг, сумын нэр	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний тоо	ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4-д заасан хяналтыг хэрэгжүүлсэн байдал					
			ИТХ			Дотоод аудит		
			Хяналт хэрэгжүүлсэн аймаг, нийслэл, сум, дүүргийн тоо	Тийм	Үгүй	Хяналт хэрэгжүүлсэн аймаг, нийслэл, сум, дүүргийн тоо	Тийм	Үгүй
1	Архангай	352	12	206	146	3	56	296
2	Баянхонгор	517	11	269	248	4	75	442
3	Баян-Өлгий	631	4	242	389	6	147	484
4	Булган	363	5	105	258	2	37	326
5	Говь-Алтай	487	8	135	352	2	18	469
6	Говьсүмбэр	91	3	59	32	3	59	32
7	Дархан-Уул	235	4	136	99	-	-	235
8	Дорноговь	235	15	235	-	-	-	235
9	Дорнод	429	9	242	187	8	198	231
10	Дундговь	317	16	317	-	4	85	232
11	Завхан	745	5	145	600	-	-	745
12	Орхон	276	3	276	-	3	276	-
13	Өвөрхангай	361	18	322	39	-	-	361
14	Өмнөговь	306	-	-	306	16	306	-
15	Сүхбаатар	323	14	323	-	14	323	-
16	Сэлэнгэ	279	13	157	122	2	29	250
17	Төв	432	1	4	428	28	432	-
18	Увс	450	9	251	199	4	68	382
19	Ховд	778	14	625	153	5	203	575
20	Хөвсгөл	539	23	456	83	8	123	416
21	Хэнтий	239	6	59	180	-	-	239
	Аймгийн дүн	8,385	193	4,564	3,821	112	2,435	5,950
22	Нийслэл	287	1	3	284	5	119	168
	Нийт дүн	8,672	194	4,567	4,105	117	2,554	6,118

³² Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих

³³ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

³⁴ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 206 дугаар тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ.



Дээрх хүснэгтээс харахад Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ болон дотоод аудитын нэгжээс хийсэн хяналт харилцан адилгүй байна.

ОНХС-ийн үйл ажиллагааны журамд ИТХ болон дотоод аудитын нэгж нь чиг үүргээ хэрэгжүүлээгүйд тооцох хариуцлагын талаар тусгагдаагүй нь журмын хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэлийг үүсгэж байгаа тул хариуцлага тооцох заалтыг тодорхой тусгаж өгөх зөвлөмжийг Сангийн Яаманд хүргүүлж байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймаг: Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 20 төсөл арга хэмжээнд аймгийн ИТХ-ын хяналтын хороо хяналт тавьж ажиллаагүй мөн Санхүүгийн хяналт аудитын албанаас аймаг, сумын ОНХС-ийн 2023 оны хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 352 ТАХ-ний 10.5 хувь буюу 37 ТАХ-нд хяналт, шалгалт хийж, 89.5 хувь буюу 296 ТАХ-нд хяналт тавьж ажиллаагүй байна.Цахир сум 20, Эрдэнэбулган сум 13, Хангай сум 22, Хашаат сум 14, Батцэнгэл сум 13, Эрдэнэмандал 40 ТАХ-нд сумын ИТХ-аас хяналт хэрэгжүүлээгүй байна.
- ✓ Булган аймаг: Аймгийн болон сумдын ИТХ-ын дэргэдэх хороодын зүгээс ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд огт хяналт хийгээгүй байна. Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын явц, гүйцэтгэлд Баян-Агт, Бугат, Дашинчилэн, Рашаант, Тэшиг сумдын ИТХ-аас хяналтыг хэрэгжүүлсэн, бусад сумдын ИТХ хяналтыг хэрэгжүүлээгүй, аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын нэгж болох СХДАА-аас аймаг, сумдын ОНХС-ийн 2023 оны үйл ажиллагаанд тусгайлан хяналт шалгалт хийгээгүй.
- ✓ Говь-Алтай аймаг: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-нд аймаг, сумдын ИТХ-аас хяналт тавьж ажиллаагүй.
- ✓ Дархан-Уул аймаг: ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр,ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэлийн явцад аймгийн ИТХ-ын дэргэдэх хороо хяналт хийх үүргээ хэрэгжүүлээгүй, барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл"-д хяналтаар өгсөн зөвлөмж, шаардлагын хэрэгжилтийн тэмдэглэл хөтөлж баталгаажуулдаггүй байна.
- ✓ Дорнод аймаг: Аймаг, сумдын ИТХ-аас ОНХС-ийн журамд заасан хяналтыг тавьж ажилласан гэх боловч тайлагналт хангалтгүй, ТАХ-ний хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй.
- ✓ Завхан аймаг: Аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ журамд заасны дагуу 24 сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр,ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналтын явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж зөвлөмж өгч ажилласан боловч хэрэгжилтийг тооцоогүй, хяналт үр нөлөө багатай байна.
- ✓ Орхон аймаг: Аймгийн ИТХ-аас Баян-өндөр, Жаргалант сумын ИТХ-д нийтийн сонсголын тухай хуулийн хүрээнд ОНХС-ийн зарцуулалтад төсвийн хяналтын сонсгол хийх ажлыг зохион байгуулах тухай албан бичиг хүргүүлснээс өөр хяналт хэрэгжүүлээгүй.
- ✓ Өвөрхангай аймаг: Аймгийн ИТХ-аас аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон ТАХ-ний санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллаагүй.
- ✓ Сэлэнгэ аймаг: ОНХС-аар хэрэгжүүлж буй ТАХ-ний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэл, тайлагналд хяналтыг бүрэн хэрэгжүүлж, үр дүнг хэлэлцэж, шийдвэрлээгүй.
- ✓ Ховд аймаг: Аймгийн ХШҮДАХ нь дэд хөтөлбөрүүдийн үнэлгээг хийхдээ нотлох баримт, судалгаа, дүн мэдээнд үндэслээгүй, байгууллагаас ирүүлсэн үнэлгээгээр үнэлсэн.
- ✓ Хөвсгөл аймаг: Аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй, Аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй, Сумдын ИТХ нь 2023 оны ОНХС-аар хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиг үүргийн хүрээнд хяналтыг хэрэгжүүлж ажилласан боловч хяналтын үр дүнг тооцож, нийтэд ил тод мэдээлэх ажил хангалтгүй байна.
- ✓ Хэнтий аймаг: Баян-Адарга, Баян-Овоо, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сум, Бэрх, Гурванбаян, Өлзийт тосгон зэрэг 7 сум тосгоны ИТХ 55 төсөл арга хэмжээнд хяналт хийсэн талаарх баримт материал ирүүлээгүй бол бусад 11 сум, тосгодын ИТХ-аас хяналт, шалгалт хийсэн талаар баримт материал ирүүлсэн боловч ТАХ-г бүрэн хамруулж хяналтыг хэрэгжүүлээгүй, аймгийн ОНХС-аас



хэрэгжүүлсэн 6,738.4 сая төгрөгийн 34 ТАХ-ний хэрэгжилтэд аймгийн ИТХ-аас хяналт хэрэгжүүлээгүй, Аймгийн ЗДТГ-ын ХШҮХДАХ нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.5-д заасны дагуу хяналт хийгээгүй байна.

Шийдвэрлэлт: Дээрх нийт 9,316.5 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 9,316.5 сая төгрөгийн 40 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.1.2 Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.3.3³⁵, 3.3.5³⁶, 3.4.3³⁷-т заасны дагуу ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтэд аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нар нь хяналт тавьж, цаашид авах хэмжээг зохион байгуулан ажиллахаар заасан.

Дүрслэл 12. Захиалагчийн хяналт



Улсын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 408,507.7 сая төгрөгийн 8,672 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байдлыг авч үзвэл 320,481.9 сая төгрөгийн 6,218 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, 88,025.7 сая төгрөгийн 2,454 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
(Дэлгэрэнгүйг судалгаа 8-аас харна уу)

Нийт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 28.3 хувьд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймгийн ОНХС 993.1 сая төгрөгийн 4 ажилд, Жаргалант сум 425.8 сая төгрөгийн 31, Цэцэрлэг сум 306.3 сая төгрөгийн 17, Эрдэнэбулган сум 379.2 сая төгрөгийн 6 нийт 2,104.4 сая төгрөгийн 58 ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй.
- ✓ Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 34, Баянбулаг сум 79.7 сая төгрөгийн 1, Бөмбөгөр сум 115.0 сая төгрөгийн 1, Галуут сум 20.0 сая төгрөгийн 1, Гурванбулаг сум 5.2 сая төгрөгийн 1, Заг сум 36.9 сая төгрөгийн 2 ажилд захиалагчийн хяналт хийгээгүй байна.
- ✓ Баян-Овоо сум ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гэрээнд хариуцлага тооцох, алданги төлүүлэх талаар тусгаагүй, Мөн сумдын малын үүлдэр угсааг сайжруулах арга хэмжээний хүрээнд худалдан авсан мал амьтдын гарал үүсэлд хяналт тавих асуудал тодорхойгүйгээс Баян-овоо суманд шүлхий, Богд суманд хонины цэцэг өвчин гарах шалтгаан нөхцөл болсон байна.
- ✓ Говь-Алтай аймаг захиалагчийн хяналт хийгээгүйгээс "8 байршилд мод усалгааны нөөцийн сав байршуулах" ажил ажлын даалгавраас зөрүүтэй, зарим эрх шилжүүлсэн ажлуудад мэргэжлийн байгууллагаас хяналт хэрэгжүүлдэггүй, төсөл арга хэмжээний чанар, гүйцэтгэл муу байна.
- ✓ Говьсүмбэр аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 430.5 сая төгрөгийн 11 ажилд захиалагчийг хяналтыг хэрэгжүүлээгүй.
- ✓ Дорнод аймаг захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ гэрээ байгуулаагүй, мэргэжлийн хуулийн этгээдээр гүйцэтгүүлээгүй.
- ✓ Дундговь аймгийн Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Өлзийт, Өндөршил, Сайнцагаан, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлд холбогдох мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналтыг хийлгээгүй,
- ✓ Завхан аймаг 20 сум ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлээгүй,

³⁵ ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

³⁶ Сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлэх цаашид авах арга хэмжээг зохион байгуулах;

³⁷ Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;



- ✓ Өвөрхангай аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1, Баянгол сум 175.1 сая төгрөгийн, Бат-Өлзий сум 175.1 сая төгрөгийн, Уянга сум 179.5 сая төгрөгийн, Бат-Өлзий сум 40.0 сая төгрөгийн, Есөнзүйл сум 207.8 сая төгрөгийн нийт 777.5 сая төгрөгийн 6 ТАХ-нд захиалагчийн хяналт тавиагүй,
- ✓ Өмнөговь аймгийн ОНХС-ийн хэрэгжүүлсэн 66.8 сая төгрөгийн 2 ажилд захиалагчийн хяналт хийгээгүй,
- ✓ Сэлэнгэ аймгийн Баянгол, Орхон, Сайхан сумд нийт 673.9 сая төгрөгийн 6 ажил, захиалагчийн болон зохиогчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй, төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үүргийг хангуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй,
- ✓ Ховд аймгийн Чандмань, Мөнххайрхан, Манхан, Буянт, Эрдэнэбүрэн, Ховд сумдад 568.2 сая төгрөгийн 6 ажилд захиалагчийн хяналт хийгээгүй, МоЭнКо ХХК, аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний 25.2-д “Талууд гэрээний хэрэгжилтийг жил бүрийн 1 дүгээр сард багтаан Аймгийн засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг дүгнэж, үнэлэлт дүгнэлт өгөх ба гэрээний хэрэгжилтийн тайланг 2 дугаар сарын 1-ны дотор аймгийн ИТХ-д хүргүүлнэ”, 25.4-д “Талууд гэрээний тухайн жилийн хэрэгжилтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэж тус тус заасан боловч одоог хүртэл гэрээг дүгнээгүй,
- ✓ Хөвсгөл аймаг: Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажилд хийгдсэн захиалагчийн хяналт хангалтгүй, дүгнэлт, тэмдэглэлд ажлын явц, гүйцэтгэлийн талаар дэлгэрэнгүй тусгадаггүй, аймаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн,
- ✓ Хэнтий аймгийн 14 сум 1,930.0 сая төгрөгийн 27, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 91.0 сая төгрөгийн 1 ажилд захиалагчийн хяналтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэлт: Дээрх зөрчилтэй холбоотой нийт 7,125.1 сая төгрөгийн зөрчилд 2.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 4,768.8 сая төгрөгийн 29 албан шаардлага, 2,353.9 сая төгрөгийн 46 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Захиалагчийн хяналт хангалтгүйгээс тухайн төсөл, арга хэмжээ чанаргүй болох, зорилтот түвшний үр дүнд хүрэхгүй байх, хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэл үүсэж байна.

3.1.3 Өмнөх аудитаар Монгол Улсын Засгийн газарт толилуулсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь ОНХС-ийн төсвийг батлахдаа өргөн мэдүүлсэн төсөл, арга хэмжээг өөрчлөн, иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээ баталж, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 дахь заалтыг хэрэгжүүлэхгүй байгаа зөрчилд хариуцлага тооцох тогтолцоо бүрдээгүй тул шат шатны ИТХ-д хариуцлага тооцох зохицуулалтыг холбогдох хуульд тусгах талаар УИХ-д өргөн мэдүүлэх” зөвлөмж хэрэгжээгүй, биелэлтийг МУЗГ-ын ХЭГ-аас ирүүлээгүй байна. Харин Сангийн яамнаас зөвлөмжийн биелэлтийг дараах байдлаар ирүүлсэн байна.

Хүснэгт 13. Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт

№	Аудитын зөвлөмж	Зөвлөмжийн биелэлт
1	Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10,11 дүгээр зүйлд заасныг бүрэн хэрэгжүүлж, Удирдлагын мэдээллийн системд хяналт тавьж, хариуцлага тооцож ажиллах	Удирдлагын мэдээллийн системд оруулсан мэдээлэлд тогтмол хяналт тавьж, хариуцлага тооцож ажиллаж байна. Үүнд: 1. Жил бүр Сангийн яамны Санхүүгийн хяналт эрсдэлийн удирдлагын газрын Санхүүгийн хяналт, шалгалтын хэлтсээс орон нутагт ажиллахдаа УМС-д мэдээлэл оруулах, ОНХС-ийн бусад үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Сангийн яамны баг орон нутагт ажиллахдаа ОНХС-ийн УМС-д үнэн зөв мэдээлэл оруулсан эсэхэд хяналт тавьж, мэдээлэл оруулаагүй болон алдаатай мэдээлэл оруулсныг тухай бүр засуулах арга хэмжээг авч ажиллаж байна. 2. Тогтвортой амьжиргаа 3 төслөөс аймгийн чадавх бэхжүүлэх баг сумдын Засаг дарга, санхүүгийн албаны ажилтнуудад ОНХС-ийн гүйцэтгэлийн үнэлгээ ил тод байдлыг сайжруулах, жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, малын тоо толгойн албан татвар, УМС-ийн үйл ажиллагааг цаашид удирдан авч явах зааварчилгаа өгөх зорилгоор аймгуудад ажилласан.
2	Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн үйл	Сар бүр УМС-д оруулсан хэрэгжилтийн тайланг авч, дүн шинжилгээ хийн анхааруулах шаардлагатай болон зөвлөмж өгөх шаардлагатай



	ажиллагааны хэрэгжилтийн тайланд дээрх журмын 9.10-т заасны дагуу дүн шинжилгээ хийж, улсын хэмжээнд нэгтгэн, түүнийг төсвийн төлөвлөлтөд ашиглах, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр бодлого боловсруулах чиг үүргээ хэрэгжүүлж, үр дүнг иргэд, олон нийтэд тайлагнаж байх	аймгуудад тусгайлан зөвлөгөө өгч ажиллаж байна. ОНХС-д аймаг, сумын ОНХС-ийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн тухайн аймаг, сумын хэрэгжилтийн тайланд оруулдаг. Мөн сар бүрийн хэрэгжилтийн тайланг shilendans.gov.mn сайтад нийтэд нээлттэйгээр байршуулдаг. Мөн ОНХС-ийн www.tusuv-oronnutag.mof.gov.mn цахим хуудас, “Орон нутгийн хөгжлийн сан” гар утасны аппликейшн, www.facebook.com/LDFMongolia , twitter.com/LDF , www.youtube.com/OponНутгийнХөгжлийнСан нийгмийн сүлжээний хуудаснууд, Фэйсбүүк дээрх “Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн бүлэг” зэрэг мэдээллийн сувгуудыг ажиллуулж, иргэдэд мэдээлэл түгээж байна.
3	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн хуваарилалт, хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний худалдан авалт, хөрөнгийн эзэмшил, хадгалалт, хамгаалалт, нягтлан бодох бүртгэлд бүртгэх, иргэдэд мэдээллийг хүртээмжтэй хүргэх, хяналт тавих үйл ажиллагаанд иргэдийн бүтцийн бүлгийн оролцоог бий болгох, Удирдлагын мэдээллийн системийг иж бүрэн ашиглах талаар журамд өөрчлөлт оруулж шинэчлэх	Төсвийн тухай хуульд ОНХС-тай холбоотой орсон нэмэлт өөрчлөлтийн хүрээнд ОНХС-ийн үйл ажиллагааны журамд өөрчлөлт оруулан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлгийг тооцох аргачлал батлах тухай” Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 457 дугаар тогтоолыг батлуулсан. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтыг үр ашигтай болгох, орон нутгийн засаглалыг дэмжих, сайжруулах зорилгоор сумдад үр дүнд суурилсан санхүүжилт буюу урамшууллын тогтолцоог туршин нэвтрүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, “Олон улсын хөгжлийн ассоциаци” хооронд байгуулсан гэрээний дагуу “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс “Сайн засаглал-үр дүнд суурилсан урамшуулал хөтөлбөр”-ийг 2017 оноос эхлэн хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд 330 сумын засаглалын түвшнийг жилийн гүйцэтгэлээр үнэлж, болзол хангасан сумдад төслийн санхүүжилтээр жил бүр урамшуулал олгож байна. “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хэрэгжих хугацаа 2023 оны 12 дугаар сард дуусгавар болсон бөгөөд жилийн гүйцэтгэлийн үнэлгээг системээр хийх, цаашид ашиглах боломжтой болсон тул урамшууллыг ОНХНС-ийн эх үүсвэр буюу Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2-т заасан эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тусгалаа. “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хугацаа дууссантай холбоотойгоор сумдын жилийн гүйцэтгэлийн үнэлгээг Сангийн яам хариуцан хийх болсонтой холбоотойгоор холбогдох өөрчлөлтүүдийг Сангийн сайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих төсвийн бодлогын хүрээнд тухайн орон нутгийн иргэдийн санал, санаачилга дээр тулгуурлан зарцуулагддаг хөрөнгийн хэмжээг сумдад нэмэгдүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн ОНХС-аас сумдын ОНХС-д итгэлцүүрээр хуваарилагдах хөрөнгийн хэмжээг 60 хувь болгох, уул уурхай, газрын тосны олборлолт хийгдэж байгаа сумдад илүү хуваарилах зорилгоор сумдын ОНХС-д хуваарилах итгэлцүүрт уул уурхайн болон газрын тосны итгэлцүүрийг нэмж 4 итгэлцүүр болгох, мөн улсын төсвөөс ОНХС-д хуваарилагддаг ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг сум дүүргийн ОНХС-д хуваарилахдаа тусгай зөвшөөрлийн талбай байрших тухайн суманд 100 хувь олгох зохицуулалтыг тусгасан.

ОНХС-ийн 2021 онд хийгдсэн аудитаар 134,165.5 сая төгрөгийн зөрчил илэрч АНТАГ-уудаас 621.4 сая төгрөгийн зөрчилд 62 төлбөрийн акт тогтоож, хэрэгжилт 87.6 хувьтай, 76,085.0 сая төгрөгийн зөрчилд 528 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилт 86.9 хувьтай, 57,458.6 сая төгрөгийн зөрчилд 566 зөвлөмж өгч, хэрэгжилт 76.4 хувьтай байна.

(Дэлгэрэнгүйг судалгаа 9-оос үзнэ үү)

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр ТЭЗҮ, зураг төсөвгүй, иргэдийн саналаар дэмжигдээгүй ТАХ хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталдаг, ХАА-ны журам зөрчсөн, хөрөнгийг бүртгэлд тусгадаггүй зөрчлүүд жил бүр давтагдан гарсаар байна
- ✓ Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын орлогч нь тус суманд ажиллах томилолтын удирдамжийг урьдчилан хүргүүлсэн байхад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажилдаа ирээгүй, аудитад шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөөгүй нь аудит хийх нөхцөл боломжоор хангаагүй, төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан.



- ✓ Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн, Ерөө, Мандал, Орхон, Сүхбаатар, Түшиг сумдын Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга, холбогдох мэргэжилтнүүд өмнөх онд хийгдсэн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тайлант онд алдаа зөрчлийг давтан гаргасан.

Шийдвэрлэлт: Дээрх зөрчилд 2 хариуцлага тооцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн байна

3.2. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг иж бүрэн тайлагнахгүй байна

3.2.1 Улсын хэмжээний 21 аймаг 330 сум, нийслэл, 9 дүүрэг ОНХС-ийн тайлан, мэдээгээ аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ болон Сангийн яаманд хэрхэн тайлагнах, хэдий хугацаанд хүргүүлэх талаар Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2, 9.3, 9.9-т тодорхой тусгасан журмын зохицуулалттай байна. Үүний дагуу 265 сум, 15 аймаг тайлан мэдээгээ журамд заасны дагуу хүргүүлсэн бол аймгийн ХБТХОХ-т тайлангаа хүргүүлээгүй 65 сум, ирүүлсэн тайланг нэгтгэн дүгнэж, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргадаа танилцуулаагүй 4 аймаг, хэрэгжилтийн тайланг нэгтгэж Сангийн яаманд хүргүүлээгүй аймгууд байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Булган аймгийн Баян-Агт, Баяннуур, Булган, Хангал, Сайхан, Сэлэнгэ, Увс, Завхан аймгийн бүх сумд, журмын 9.2-т заасны дагуу ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг хүргүүлээгүй, Нийслэлийн 9 дүүрэг хүргүүлсэн ч 28-35 хоног хугацаа хоцроосон,
- ✓ Баянхонгор, Говьсүмбэр, Хөвсгөл, Хэнтий аймгуудын ЗДТГ-ын ХБТХОХ нь сумдаас ирүүлсэн хэрэгжилтийн тайланд журмын 9.3-т заасны дагуу дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулаагүй,
- ✓ Дархан-Уул, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Увс аймгууд журмын 9.9-т заасны дагуу хэрэгжилтийн тайланг нэгтгэж Сангийн яаманд хүргүүлээгүй,

Шийдвэрлэлт: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх 12 зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлсэн байна.

3.2.2. Улсын хэмжээнд 2023 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон 29,723.6 сая төгрөгийн бараа материал, 370,689.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нийт 400,413.0 сая төгрөгийн хөрөнгийг төсөвт байгууллагуудын болон нийтийн эзэмшлийн данс бүртгэлд аймгийн ИТХ-ын тогтоол, сумдын Засаг даргын захирамжийг үндэслэн бүртгэл тайланд тусгасан бол 83,700.9 сая төгрөгийн хөрөнгийг урсгал зардлаар тайлагнасан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон нийт 25,849.5 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2. “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”-ыг гэж заасныг зөрчиж байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймаг 1,035.7 сая төгрөг, Баянхонгор 305.8 сая төгрөг, Баян-Өлгий 449.6 сая төгрөг, Булган 46.4 сая төгрөг, Говь-Алтай 3,458.4 сая төгрөг, Дархан-Уул 1,279.1 сая төгрөг, Дорноговь 276.0 сая төгрөг, Дорнод 71.2 сая төгрөг, Завхан 478.6 сая төгрөг, Өвөрхангай 169.8 сая төгрөг, Сэлэнгэ 2,724.3 сая төгрөг, Төв 9,366.4 сая төгрөг, Увс 20.0 сая төгрөг, Ховд 283.4 сая төгрөг, Хөвсгөл 3,474.0 сая төгрөг, Хэнтий 403.0 сая төгрөг, Нийслэл 7,119.6 сая төгрөг, нийт 32,969.1 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.
- ✓ Өвөрхангай аймаг 447.5 сая төгрөгийн хөрөнгийг буруу тайлагнасан, 1,054.9 сая төгрөгийн авлагыг бүртгээгүй, Ховд аймаг 19.7 сая төгрөгийн авлагыг бүртгэлд тусгаагүй,
- ✓ Говь-Алтай аймагт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний 485.6 сая төгрөгийн гүйлгээг и-баримтгүй хийсэн.



Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх нийт 25,849.5 сая төгрөгийн зөрчилд 22,744.8 сая төгрөгийн 50 албан шаардлага, 3,104.7 сая төгрөгийн 6 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.2.3. ОНХС-ийн удирдлагын мэдээллийн систем нь ОНХС-аас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийн санг бүрдүүлэх зорилготой бөгөөд тус төсөл, арга хэмжээ хэрэгжиж буй эсэхэд хяналт тавих боломжийг бүрдүүлэх, цаашид системээр дамжуулан мэдээллийн сан бүрдүүлж, хуваарилалт, төлөвлөлт хийх, төслийн санхүүжилт, гүйцэтгэлийг удирдах, тайлагнах, үнэлгээ хийхэд ашиглах зорилготой хэрэгжиж эхэлсэн систем юм. Тус системийг Тогтвортой амьжиргаа-3 төслийн хүрээнд “Могул консалтинг” ХХК-аар гүйцэтгүүлсэн бөгөөд 2023 оны 3 дугаар сарын 24-өөс 8 дугаар сарын 1-ний хооронд УМС-ийг сайжруулан, хөгжүүлэх ажлыг хийсэн байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2³⁸ дахь заалтын дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнал, хяналт, бүртгэлийг аймаг, сумдын ЗДТГ нь удирдлагын мэдээллийн системд оруулах чиг үүрэгтэй.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд 483,438.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9,938, нийслэл 60,951.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 392 нийт улсын хэмжээнд 544,390.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10,330 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталснаас удирдлагын мэдээллийн системд 60.8 хувь буюу 6276 ТАХ-г бүрэн мэдээлж, 8.6 хувь буюу 885 ТАХ-г дутуу мэдээлж, 30.7 хувь буюу 3169 ТАХ-г мэдээлээгүй байна.

Харин Орхон, Сүхбаатар аймгууд удирдлагын мэдээллийн системд оруулбал зохих бүх ТАХ-г бүрэн оруулж тайлагнасан **сайн жишээ** байна.

Хүснэгт 14. Удирдлагын мэдээллийн системийн мэдээлэл

(сая төгрөгөөр)

Аймаг, нийслэл	ИТХ-аар батлагдсан нийт ТАХ-ний тоо	Бүрэн оруулсан ТАХ-ний тоо	Дутуу оруулсан ТАХ-ний тоо	Огт оруулаагүй ТАХ- ний	
				тоо	хувь
Аймгууд	9,938	6,254	877	2,807	28.2%
Нийслэл	392	22	8	362	92.3%
Нийт дүн	10,330	6,276	885	3,169	30.7%

УМС-д оруулаагүй ТАХ-г аймаг, нийслэлээр нь авч үзвэл аймгууд оруулбал зохих нийт төсөл арга хэмжээний 28.2 хувь буюу 2807 ТАХ-г, Нийслэл 92.3 хувь буюу 362 ТАХ-г удирдлагын мэдээллийн системд огт мэдээлээгүй байна.

УМС-д байршуулсан ОНХС-ийн талаарх мэдээллийг, АНТАГ-уудын судалгааны дүнтэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 15. УМС болон судалгааны мэдээллийн харьцуулалт

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Батлагд- сан төсөв	Санхүүжилт	Нийт гэрээний дүн	Зарцуулалт	Санал өгсөн иргэд	Ашиглалтанд орох ТАХ- ний тоо
УМС-д барйшуулсан мэдээлэл	190,788.0	564,138.0	281,196.0	219,659.0	855,729	6637
АНТАГ-уудын судалгааны мэдээлэл	544,389.9	426,489.8	521,864.4	408,507.6	2,080,367	8672
зөрүү	(353,601.9)	137,648.2	(240,668.4)	(188,848.6)	(1,224,638.0)	(2,035.0)

Хүснэгтээс харахад АНТАГ-уудын нэгтгэсэн судалгааны нэгтгэсэн дүнгээр хэрэгжсэн ТАХ 8,672 байхад УМС-д 6,637 байгаа нь аймаг, сумын ЗДТГ-аас бодит үзүүлэлтээс мэдээллийг системд

³⁸ ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ



байршуулж байгааг баталж байна. Аудитын явцад иргэдээс авсан **“ОНХС-ийн мэдээллийг хаанаас авдаг вэ?”** гэсэн асуулгад 9 хувь нь **“удирдлага мэдээллийн системээс”** гэж хариулсан бол **“ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системээс та ямар төрлийн мэдээлэл авдаг вэ?”** гэсэн асуулгад иргэдийн 26 хувь нь “төсөл арга хэмжээний гүйцэтгэл биелэлттэй холбоотой”, 12 хувь нь “сангийн хөрөнгийн төлөвлөлттэй холбоотой”, 12 хувь нь “сангийн хөрөнгийн тайлан мэдээтэй холбоотой”, 42 хувь нь “мэдээлэл авдаггүй” гэж хариулсан байна.

Иргэдийн хувьд удирдлагын мэдээллийн системээс өөрийн болон бусад аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй авах боломжтой бөгөөд энэхүү боломжоо бүрэн эдэлж чадахгүйд хүрч байна.

Тус системийг иргэд олон нийтэд таниулах ажил хангалтгүй, хүний нөөцийн тогтворгүй байдал, мэдээлэл оруулах эрх бүхий албан тушаалтнуудын интернэт орчинд ажиллах чадвар болон программын талаарх мэдлэг, мэдээлэл сул байгаагаас систем бүрэн ашиглагдахгүй байна.

Иймд удирдлагын мэдээллийн системийн талаарх мэдээллийг иргэдэд сурталчлан таниулах, холбогдох албан хаагчдыг арга зүйгээр хангах, системийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

Аймаг, сум, дүүргийн СТСХ, ЗДТГ-ууд нь ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, тайлагналт, бүртгэлийг удирдлагын мэдээллийн системд оруулах, иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх үүргээ хангаж ажиллаагүй, төлөвлөсөн нийт ТАХ-ний 39.2 хувийг удирдлагын мэдээллийн системд дутуу болон огт мэдээлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 3,493.1 сая төгрөгийн 17 ТАХ, Жаргалант сум 928.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 37 ТАХ, Эрдэнэбулган сум 146.3 сая төгрөгийн 1 ТАХ, Тариат сум 666.9 сая төгрөгийн 34 ТАХ, Ихтамир сум 572.2 сая төгрөгийн 21 ТАХ, Эрдэнэмандал сум 414.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ТАХ-ний мэдээллийг дутуу, 54.5 сая төгрөгийн 5 ТАХ, Хотонт сум 658.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 ТАХ-ний мэдээллийг УМС-д оруулаагүй.
- ✓ Баян-Өлгий аймгийн Ногооннуур, Цэнгэл, Цагааннуур, Бугат, Булган, Буянт, Толбо сумд ОНХС-ийн мэдээллийг УМС-д оруулаагүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг дахин давтан гаргасан.
- ✓ Баянхонгор аймаг “ОНХС-ийн үйл ажиллагаа”-ын журмын 10.3.2 дахь “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн ОНХС-ийн УМС-ийн хэрэгжилт цэсэд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг хийнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйгээс аймаг, сумын УМС-д мэдээлэл оруулаагүй байхад аймаг, сумын төрийн сан гүйлгээ хийсэн.
- ✓ Булган аймаг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 985.9 сая төгрөгийн 3 мэдээлэл дутуу, 113.6 сая төгрөгийн 1 мэдээлэл оруулаагүй, 7 сум нь 1,237.4 сая төгрөгийн 24 мэдээлэл дутуу, 11 сум нь 1,345.0 сая төгрөгийн 88 мэдээллийг нээлттэй ил тод мэдээлээгүй.
- ✓ Говь-Алтай аймаг, сумдын ОНХС-ийн УМС-д 41 ТАХ-ний мэдээллийг дутуу, 386 ТАХ-г байршуулаагүй.
- ✓ Говьсүмбэр аймаг 1,077.1 сая төгрөгийн батлагдсан төсөв, гэрээ байгуулсан дүн, зарцуулалтыг оруулаагүй, Баянтал сум 67.4 сая төгрөгийн батлагдсан төсөв, 43.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан дүнг оруулаагүй, Шивээговь сум 158.1 сая төгрөгийн батлагдсан төсөв, 566.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан дүн, 336.3 сая төгрөгийн зарцуулалтыг оруулаагүй, Сүмбэр сум 597.9 сая төгрөгийн батлагдсан төсөв, 784.4 сая төгрөгийн гэрээ байгуулсан дүн, 654.9 сая төгрөгийн зарцуулалтыг оруулаагүй.
- ✓ Дархан-Уул аймаг 7,552.6 сая төгрөгийн 110 ТАХ, Орхон сум 722.1 сая төгрөгийн 13 ТАХ, нийт 8,274.7 сая төгрөгийн 123 ТАХ-ний мэдээллийг оруулаагүй байна
- ✓ Дорноговь аймаг УМС-д 92 ТАХ тус бүрээр төсөвт өртөг, гэрээний дүн, олгосон санхүүжилт, ажлын явцын зураг зэргийг оруулахаас мэдээллийг зөрүүтэй оруулах, мэдээлэхгүй орхигдуулах, ажлын явцын зургийг оруулаагүй.



- ✓ Дорнод 118 ТАХ-ний мэдээллийг УМС-д оруулаагүй.
- ✓ Дундговь аймгийн Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Цагаандэлгэр, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Сайнцагаан, Өлзийт сумд нийт 91 ТАХ-ний мэдээллийг УМС-д оруулаагүй.
- ✓ Завхан аймгийн 17 сум 329 ТАХ-ний ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг УМС-д дутуу болон зөрүүтэй, огт мэдээлээгүй.
- ✓ Өвөрхангай аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 35 ТАХ-ний хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийн мэдээллийг УМС-д үнэн зөв оруулаагүй.
- ✓ Өмнөговь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 163.9 сая төгрөгийн 227 ТАХ-ний мэдээллийг УМС-д оруулаагүй.
- ✓ Сэлэнгэ аймгийн 8 сум 43 ТАХ-ний мэдээллийг УМС-д оруулаагүй.
- ✓ Төв аймаг “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлд заасны дагуу 245 ТАХ-ний хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийг удирдлага мэдээллийн системд бүрэн оруулаагүй.
- ✓ Хөвсгөл аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 23 ТАХ, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 42 ТАХ-ний мэдээллийг УМС-д зөрүүтэй мэдээлсэн.
- ✓ Хэнтий аймаг 9,346.1 сая төгрөгийн 36 ТАХ, Дархан сум 234.7 сая төгрөгийн 8 ТАХ, Дадал сум 156.3 сая төгрөгийн 4 ТАХ, Биндэр сум 151.5 сая төгрөгийн 6 ТАХ, Өмнөдэлгэр сум 99.0 сая төгрөгийн 1ТАХ, Өлзийт тосгон 82.1 сая төгрөгийн 3 ТАХ, Батширээт сум 59.5 сая төгрөгийн 2 ТАХ, Мөрөн сум 35.4 сая төгрөгийн 2 ТАХ, Хэрлэн сум 15.0 сая төгрөгийн 1 ТАХ, Дэлгэрхаан сум 12.3 сая төгрөгийн 1 ТАХ, Баянмөнх сум 10.0 сая төгрөгийн 1 ТАХ, Цэнхэрмандал сум 2.5 сая төгрөгийн 1 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй, 50 ТАХ-ний мэдээллийг дутуу оруулсан.
- ✓ Нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 362 ТАХ-ний зарцуулалт үр дүнгийн талаар УМС-д оруулаагүй.
- ✓ Увс аймаг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 134 ТАХ-ний мэдээллийг оруулаагүй.
- ✓ Ховд аймаг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 168 ТАХ-ний мэдээллийг оруулаагүй.
- ✓ 18 аймаг, нийслэл 885 ТАХ-г удирдлагын мэдээллийн системд мэдээллийг оруулахдаа зөрүүтэй, дутуу оруулсан байна.

Шийдвэрлэлт: Аудитаар дээрх 36,913.9 сая төгрөгийн зөрчилд 21 албан шаардлага, 35,936.8 сая төгрөгийн 38 зөвлөмж, 977.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргасан 6 сумын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлжээ.

“ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 10.3.3-т “ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д зохих журмын дагуу оруулаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл ОНХНС, аймаг, нийслэлийн ОНХС-аас орлогын шилжүүлэг олгохгүй” гэсэн хатуу заалттай ч энэхүү заалтыг шат шатандаа хэрэгжүүлж ажиллахгүй байгаа нь удирдлагын мэдээллийн системд төсөл, арга хэмжээний мэдээллийг дутуу болон огт оруулдаггүй зөрчил давтагдсаар байна.

Иймд ОНХНС-аас санхүүжилтийг олгохдоо “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 10.3.3 дахь заалтын дагуу тухайн зөрчлийг бүрэн арилгах хүртэл санхүүжилтийг олгохгүй байх арга хэмжээг авч ажиллахыг Сангийн яаманд хүргүүллээ.

3.2.4. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2³⁹, 3.2.2, 6 дугаар зүйлийн 6.1⁴⁰, 6.1.1⁴¹, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 11 дүгээр хавсралтын

³⁹ Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна.

⁴⁰ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ,

⁴¹ тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор.



хүрээнд www.shilendans.gov.mn цахим хуудсанд ОНХС-ийн төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор тогтмол мэдээлэхээр заасан.

Гэтэл зарим аймаг, сум, дүүргийн ОНХС хариуцсан албан тушаалтнууд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ОНХС-ийн 2023 оны хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг огт мэдээлээгүй, зөрүүтэй, дутуу, хугацаа хоцроож мэдээлсэн дараах зөрчил гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймгийн Өндөр-Улаан, Ихтамир сум 5 ТАХ-г мэдээлээгүй, 19 ТАХ-г хугацаа хоцроосон, Ихтамир сум 13 ТАХ-г мэдээлээгүй,
- ✓ Баянхонгор аймаг ОНХС-ийн төлөвлөгөөг хугацаа хоцроосон,
- ✓ Говь-Алтай ОНХС-ийн гүйцэтгэлийг мэдээлээгүй,
- ✓ Говьсүмбэр аймаг ОНХС-ийн төсөв, гэрээний дүнг дутуу мэдээлсэн, төлөвлөгөө, гүйцэтгэлийг хугацаа хоцроосон, Сүмбэр сум төлөвлөгөөг мэдээлээгүй, Шивээговь, Баянтал сум төлөвлөгөө гүйцэтгэлийг хугацаа хоцроосон,
- ✓ Дархан-Уул аймаг 67 ТАХ-г хугацаа хоцроосон, 11 ТАХ-г мэдээлээгүй,
- ✓ Дорноговь аймгийн Айраг, Алтан ширээ, Дэлгэрэх, Хатанбулаг сумд ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тушаал шийдвэрийг мэдээлээгүй,
- ✓ Дорнод аймаг ОНХС-ийн мэдээллийг иргэдэд ил тод мэдээлээгүй,
- ✓ Дундговь аймгийн Дэрэн, Сайхан-Овоо, Хулд, Цагаан дэлгэр, Эрдэнэдалай сумд ОНХС-ийн гүйцэтгэлийг үнэн зөв, иж бүрэн мэдээлээгүй,
- ✓ Сүхбаатар аймаг ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өссөн дүнгээр, гүйцэтгэгчийн нэр, регистр, тендер шалгаруулалтын журам зэргийг бүрэн мэдээлээгүй,
- ✓ Хэнтий аймгийн Биндэр, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Гурванбаян сумд 9 ТАХ-ний төлөвлөлт, 11 ТАХ-ний гүйцэтгэлийг мэдээлээгүй, Баян-Адарга, Жаргалтхаан, Норовлин сумд үнийн дүнг зөрүүтэй мэдээлсэн,
- ✓ Нийслэл ОНХС-ийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэлт: Шилэн дансны тухай хуулийг хангаж ажиллаагүй нийт 6,297.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 6,297.8 сая төгрөгийн 22 зөвлөмж хүргүүлсэн байна.

Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээллийг хугацаа хоцроодог, дутуу, зөрүүтэй байршуулдаг, огт мэдээлдэггүй зэрэг зөрчил нь Шилэн дансны тухай хуульд заасан зарчим алдагдахаас гадна, иргэд олон нийт, хэрэглэгчдэд буруу ойлголт төрүүлэх, үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээллийг олж авахгүй байх үр дагаврыг үүсгэж байна.



ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Газрын тосны нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого 2023 онд бүрэн төвлөрөөгүйгээс ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг дутуу санхүүжүүлсэн байна.
2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь ОНХС-ийн хөрөнгийг эх үүсвэр тус бүрээр бүрэн төлөвлөх талаар санаачилгатай ажиллаагүй, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд иргэд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг хэт жижиглэснээс тендер оролцогчгүй болох, оройтох, ажил он дамнах, төсөл арга хэмжээний гүйцэтгэл, чанарт сөргөөр нөлөөлж байна.
